

ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН
2020 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

2020.12.08

Дархан-Уул аймаг

Тус хэлтэс нь 2020 онд “Улсын бүртгэлийн үйл ажиллагааг хууль тогтоомжид заасны дагуу зохион байгуулж, хэрэгжүүлэхэд оршино” гэсэн зорилт дэвшүүлэн “Сэтгэл, зүтгэл, гүйцэтгэлийг эрхэмлэх” гэсэн уриатайгаар иргэний, эд хөрөнгийн эрхийн, хуулийн этгээдийн улсын бүртгэл, бүртгэл хяналтын чиглэлээр үйл ажиллагаа явуулж, бүртгэлийн үйлчилгээг иргэдэд ил тод, түргэн шуурхай, чирэгдэлгүй, үнэн зөв, хүртээмжтэй хүргэх, нутаг дэвсгэрийн хэмжээнд Монгол Улсын Үндсэн хууль, Төрийн албаны тухай хууль, Улсын бүртгэлийн ерөнхий хууль, Иргэний улсын бүртгэлийн тухай хууль, Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хууль, Үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны тухай хууль, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль, Архивын тухай хууль болон холбогдох бусад эрх зүйн актуудын хэрэгжилтийг ханган дараах ажлуудыг тайлангийн хугацаанд хийж гүйцэтгэлээ.

***НЭГ. ДЭЭД БАЙГУУЛЛАГЫН ШИЙДВЭРИЙГ ХЭРЭГЖҮҮЛСЭН
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН***

Тус хэлтэс нь дараах Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын тушаал, албан бичгээр ирүүлсэн үүрэг даалгавар, зөвлөмж, чиглэлүүдийг бүртгэлийн үйл ажиллагаандаа мөрдөж хэрэгжилтийг ханган ажилласан. Үүнд:

УБЕГ-ын даргын тушаалын хэрэгжилт:

1. Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1, 25.2-т заасны дагуу Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын “Иргэний шилжилт хөдөлгөөнийг зогсоох тухай” 2020 оны 01 дүгээр сарын 27 ны өдрийн А/126 дугаар тушаалын хэрэгжилтийг ханган ажиллаж иргэний засаг захиргааны нэг нэгжээс нөгөө нэгжид шилжин суурьших хөдөлгөөнийг 2020 оны 02 дугаар сарын 01 –ний өдрөөс Монгол Улсын Их Хурлын ээлжит сонгуулийн санал авах өдрийг дуустал түр зогсоосон.

2. Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын “Зохион байгуулалтын арга хэмжээ авах тухай” 2020 оны 03 дугаар сарын 09 ний өдрийн А/255, “Ажлын тусгай горимд шилжүүлэх тухай” 2020 оны 03 дугаар сарын 13 ны өдрийн А/259, “Журам, маягт, загвар батлах тухай” 2020 оны 03 дугаар сарын 24 ний өдрийн А/372, “Ажлын тусгай горимд шилжүүлсэн хугацааг сунгах тухай” 2020 оны 03 дугаар сарын 31 ний өдрийн А/419, “Итгэмжлэгдсэн ажилтны орон тооны

хязгаарыг батлах тухай” 2020 оны 04 дүгээр сарын 22 ны өдрийн А/521, “Ажлын тусгай горимд шилжүүлсэн хугацааг сунгах тухай” 2020 оны 04 дүгээр сарын 30 ны өдрийн А/554, “Сонгууль зохион байгуулах зардлын төсөв батлах тухай” 2020 оны 05 дугаар сарын 06 ны өдрийн А/595, “Зардал гаргах тухай” 2020 оны 06 дугаар сарын 22 ны өдрийн А/856, “Иргэний шилжилт хөдөлгөөнийг сэргээх тухай” 2020 оны 06 дугаар сарын 23 ны өдрийн А/858, “Журам, маягт, загвар батлах тухай” 2020 оны 07 дугаар сарын 07 ны өдрийн А/961, “Иргэний шилжилт хөдөлгөөнийг түр зогсоох тухай” 2020 оны 08 дугаар сарын 07 ны өдрийн А/1168, “Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 2020 оны 08 дугаар сарын 11 ний өдрийн А/1172, “Журам батлах тухай” 2020 оны 08 дугаар сарын 27 ны өдрийн А/1287, “Итгэмжлэгдсэн ажилтны орон тооны хязгаарыг батлах тухай” 2020 оны 08 дугаар сарын 21 ний өдрийн А/1271, “Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгууль зохион байгуулах зардлын төсөв батлах тухай” 2020 оны 09 дүгээр сарын 02 ны өдрийн А/1304, “Иргэний шилжилт хөдөлгөөний бүртгэлийг сэргээх тухай” 2020 оны 10 дугаар сарын 16 ны өдрийн А/1389, “Зардал гаргах тухай” 2020 оны 10 дугаар сарын 23 ны өдрийн А/1424, “Гамшгийн үеийн орон тооны бус шуурхай штаб байгуулах тухай” 2020 оны 11 дүгээр сарын 16 ны өдрийн А/1455, Улсын бүртгэлийн ерөнхий газрын дарга, Архивын ерөнхий газрын даргын хамтарсан “Хадгалах хугацааны жагсаалт шинэчлэн батлах тухай” 2020 оны 11 дүгээр сарын 02 ны өдрийн А/14371-А/110 дугаар тушаалуудын хэрэгжилтийг ханган ажилласан.

3. Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2020 оны 02 дугаар сарын 12 ны өдрийн Б/81, 2020 оны 03 дугаар сарын 20 ны өдрийн Б/156, 2020 оны 04 дүгээр сарын 02 ны өдрийн Б/173, 2020 оны 04 дүгээр сарын 10 ны өдрийн Б/182, 2020 оны 06 дугаар сарын 19 ний өдрийн Б/304, 2020 оны 07 дугаар сарын 21 ний өдрийн Б/351, 2020 оны 09 дүгээр сарын 30 ны өдрийн Б/506, 2020 оны 10 дугаар сарын 21 ний өдрийн Б/548, 2020 оны 10 дугаар сарын 28 ны өдрийн Б/562, Б/563, Б/564, Б/565, Б/566, Б/567, 2020 оны 10 дугаар сарын 29 ний өдрийн Б/569 дугаар тушаалуудын хэрэгжилтийг тус тус ханган ажиллаж тухай бүр нь холбогдох албан хаагчдад танилцуулан зохих журмын дагуу ажлыг хүлээлцүүлж, холбогдох акт тэмдэглэлийг үйлдэж баталгаажуулан ажилласан.

Бүртгэлийн холбогдох чиглэлийн газраас ирүүлсэн чиглэл, зөвлөмжийн хэрэгжилт:

Иргэний улсын бүртгэлийн газраас ирүүлсэн чиглэл зөвлөмж:

1. 2020 оны 01 дүгээр сарын 28 ны өдрийн 5/850 тоот албан бичгээр ирүүлсэн чиглэлийн дагуу дараах ажлыг хийж гүйцэтгэсэн. Үүнд:

- Шилжилт хөдөлгөөний бүртгэлд бүртгүүлсэн, тухайн засаг захиргааны нэгжид байнга оршин суух иргэний мэдээллийг иргэний улсын бүртгэлийн цахим мэдээллийн санд нягтлан шалгаж, 2020 оны 01 дүгээр сарын 31 ний өдрөөс өмнө бүртгэсэн төлөвтэй иргэний мэдээллийг баталгаажуулж дуусгасан.

- 2020 оны 01 дүгээр сарын 31 ний өдөр хөтлөгдсөн шилжилт хөдөлгөөний бүртгэлийг тухайн өдөр /2020 оны 01 дүгээр сарын 31/ -ийн 24.00 цагаас өмнө иргэний улсын бүртгэлийн цахим мэдээллийн санд бүртгэж баталгаажуулсан.

- Сумдын улсын бүртгэгч нар өөрийн биеэр хэлтэс дээр ирж иргэний улсын бүртгэлийн офлайн сан, онлайн сан, дэвтэрт бүртгэсэн шилжилт хөдөлгөөний бүртгэлийн ИУБ-22 маягтыг жагсаалт, нотлох баримтын хамт хүлээлгэн өгсөн бөгөөд шилжилт хөдөлгөөний бүртгэлийн ИУБ-22 маягтыг нотлох баримттай тулган шалгаж улсын бүртгэлийн мэдээллийн санд тогтоосон хугацаанд бүртгэж баталгаажуулалтыг хийсэн.

- Шилжилт хөдөлгөөний бүртгэлийг тогтоосон хугацаанд зогсоон 2020.01.31 ний өдрийн 17.30 – 20.00 цагт сумдын улсын бүртгэгч нараас шилжилт хөдөлгөөний бүртгэлийн дэвтрүүдийг нь хүлээн авч сүүлийн бүртгэлээр шугам татан “шилжилт хөдөлгөөний бүртгэлийг түр зогсоосон” тухай тэмдэглэгээг хийж ИУБ-22 маягтын үлдэгдлийн хамт хураан чиглэлийн дагуу хийж гүйцэтгэсэн ажлын илтгэх хуудсыг 2020 оны 02 дугаар сарын 03 ны өдрийн 174 тоот албан бичгээр хүргүүлсэн.

2. 2020 оны 02 дугаар сарын 27 ны өдрийн 5/1858 тоот албан бичгээр ирүүлсэн чиглэлийн дагуу дараах ажлыг хийж гүйцэтгэсэн. Үүнд:

- Сонгуулийн хэсэг байгуулж, хэсгийн нутаг дэвсгэр, төвийг зарласан сумдын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн тогтоолуудыг хүлээн авахдаа эх хувь мөн эсэх, тамга дарагдаж, гарын үсэг зурж баталгаажсан эсэхийг сайтар шалгаж, эх хувийг 2020 оны 02 дугаар сарын 21 ний өдрийн 321 тоот албан бичгээр болон t.enkhbaatar@burtgel.gov.mn, ts.javkhlant@burtgel.gov.mn цахим хаягуудаар хугацаанд нь хүргүүлсэн.

- Иргэний улсын бүртгэлийн мэдээллийн санд хэсгийн нутаг дэвсгэр, санал авах байрны мэдээлэл, сонгуулийн эрх бүхий иргэнийг сонгуулийн хэсэгт бүртгэх эрх хүссэн 2020 оны 03 дугаар сарын 04 ний өдрийн 342 тоот албан бичгийг цаасаар болон sonquuli2020@burtgel.gov.mn цахим хаягаар хүргүүлэн эрх авсан.

- Эрх авсан улсын ахлах бүртгэгч, улсын бүртгэгч нар 4 сумын 39 сонгуулийн хэсэгт хамаарах санал авах байр буюу хэсгийн төв түүнд хамаарах 1829-н хаягийн мэдээллийг тусгаж баталгаажуулсан.

- Хэсэг оноогдоогүй үлдсэн сонгуулийн эрх бүхий 79-н иргэний хаягийн мэдээллийг нягтлан шалгаж хэсэг оноох ажлыг хийж гүйцэтгэсэн.

- Тус аймгийн 69984-н сонгуулийн насны иргэний байнга оршин суугаа хаягийн бүртгэл, эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, төрсөн он, сар, өдөр, ижил, регистрийн дугаар давхардсан байж болзошгүй 116-н сонгогчийн бүртгэлийг нягтлан шалгахад зөрчил илрээгүй.

- Сонгуулийн хэсэг оноох явцад үүссэн асуудлыг тухай бүр нь Мэдээлэл технологийн газрын албан хаагчтай холбогдож зөвлөгөө, мэдээллийг авч ажилласан бөгөөд ямар нэгэн хүндрэл гараагүй.

- Сумдын улсын бүртгэгч нар иргэний үнэмлэхний бүртгэл, биеийн давхцахгүй өгөгдлийн бүртгэл хөтлөхдөө иргэний улсын бүртгэлийн тухай хууль тогтоомжид заагаагүй баримт бичгийг иргэдээс шаардахгүй байх, аливаа ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх тухай зөвлөгөө мэдээллийг өгч тогтмол хяналт тавин ажилласан.

Чиглэлийн дагуу хийж гүйцэтгэсэн ажлын илтгэх хуудсыг хугацаанд нь 2020 оны 04 дүгээр сарын 02 ны өдрийн 455 тоот албан бичгээр хүргүүлсэн.

3.2020 оны 04 дүгээр сарын 16 ны өдрийн 5/3701 тоот албан бичиг, 7, 8 дугаар саруудад цахимаар ирүүлсэн чиглэлүүдийн дагуу иргэний улсын бүртгэлийн программыг шинэчлэн хэрэглээнд нэвтрүүлэхтэй холбогдуулан холбогдох программд бүртгэлийн төрөл тус бүрээр туршилтыг хийж гүйцэтгэж холбогдох тайлан, илтгэх хуудас, саналыг тухай бүр нь хугацаанд нь хүргүүлж ажилласан.

4.2020 оны 04 дүгээр сарын 21 ний өдрийн 5/3846 тоот албан бичгээр ирүүлсэн чиглэлийн дагуу дараах ажлыг хийж гүйцэтгэсэн. Үүнд:

- Иргэний улсын бүртгэлийн цахим мэдээллийн сан дахь “Санал авах байрны бүртгэл” цэснээс сонгуулийн хэсгийн төвд хамаарах нутаг дэвсгэрт бүртгэгдээгүй хаягийн жагсаалтыг сумдын Иргэдийн Төлөөлөгчдын Хурлын Тэргүүлэгчдийн батлагдсан хүчин төгөлдөр тогтоолын эх хувьтай нэг бүрчлэн шалгасан.

- Шалгахад Дархан сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн хэсгийн нутаг дэвсгэр, төвийг тогтоосон тогтоолд тусгагдаагүй буюу орхигдсон, бичвэрийн хувьд буруу бичигдсэн 24 хаягийг илрүүлэн тус хаягуудыг тогтоолд тусгуулан өөрчлөлт оруулуулахаар тус сумын Засаг даргад 2020 оны 04 дүгээр сарын 29-ний өдөр тус хэлтсийн 650 тоот албан бичгээр хандсаны дагуу Дархан сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын “Тогтоолын

хавсралтад өөрчлөлт оруулах тухай” 2020 оны 05 дугаар сарын 01-ний өдрийн 23 дугаар тогтоолын эх хувийг тус хэлтэст ирүүлсэн.

- Тус хэлтсийн иргэний улсын ахлах бүртгэгч сумдын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн тогтоол дахь сонгуулийн хэсэгт хамаарах нутаг дэвсгэрт байнга оршин суугаа газрын хаягийн бүртгэлтэй сонгуулийн эрх бүхий иргэний мэдээллийг тогтмол шалгаж ажилласан бөгөөд хэсэг оноогдоогүй орхигдсон болон хэсэг зөрүүлж оноосон зөрчил илрээгүй.

- УБЕГ-ын Иргэний улсын бүртгэлийн газраас ирүүлсэн овог, эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, төрсөн он, сар, өдөр ижил 167-н иргэний мэдээллийг иргэний улсын бүртгэлийн мэдээллийн сангаас дахин нэг бүрчлэн шүүж, сонгуулийн аль хэсэгт бүртгэгдсэнийг нягталж шалган тэмдэглэл хөтөлсөн.

- 2017 оноос хойш нийт 67-н иргэний регистрийн дугаар өөрчилсний бүртгэлийг хөтөлсөн байгаа бөгөөд иргэний улсын бүртгэлийн мэдээллийн сантай тулган шалгахад өөрчлөлтийн бүртгэл санд бүрэн тусгагдсан, зөрчилгүй байсан.

- 2017 оноос 2020 оны 05 дугаар сарын 04-ний өдрийн байдлаар хүйс зөрүүлж олгосон шалтгаанаар 6 иргэний регистрийн дугаар өөрчилсөн бүртгэл хөтөлсөн. Бүртгэлийг иргэний улсын бүртгэлийн мэдээллийн сантай тулган шалгахад өөрчлөлтийн бүртгэл санд бүрэн тусгагдсан, зөрчилгүй байна. Энэ 6 иргэнээс сонгуулийн насны 2 иргэн байсны 1 иргэн нь иргэний үнэмлэхээ сольж аваагүй байсан зөрчлийг илрүүлэн 2020 оны 05 дугаар сарын 01-ний өдөр үнэмлэхийг нь захиалуулан зөрчлийг арилгасан.

- Давхар регистрийн дугаартай шалтгаанаар хяналтын улсын байцаагчийн дүгнэлтээр регистрийн дугаар өөрчлөгдсөн бүртгэл 2017 оноос 2020 оны 05 дугаар сарын 04-ний өдрийн байдлаар хөтлөгдөөгүй.

- Чиглэлийн дагуу биеийн давхцахгүй өгөгдлийн бүртгэлд шинээр, 25, 45 насанд сольж, үрэгдүүлсэн шалтгаанаар дахин олгох бүртгэлд бүртгүүлж байгаа иргэдийн бүртгэлийг баталгаажуулахдаа иргэний байнга оршин суух хаягийн мэдээлэл сонгуулийн хэсэгт хамаарах нутаг дэвсгэрт бүртгэгдсэн эсэхийг нягтлан шалгаж баталгаажуулалтыг хийсэн.

- Улсын бүртгэлийн үйлчилгээ авахаар ирсэн иргэдэд улсын бүртгэлийн цахим хуудсанд байршуулсан сонгогчдийн нэрийн жагсаалт дахь өөрт холбогдох мэдээлэлтэй танилцах боломжийг хангах ажлын хүрээнд сумдын улсын бүртгэгч нарт мэдээлэл өгч, хэрхэн танилцуулж ажиллах талаар утсаар болон цахимаар чиглэл өгч ажилласан.

Тус аймаг дахь Тагнуулын хэлтсээс санал авахаар 39-н сонгуулийн хэсгийн итгэмжлэгдсэн ажилтнаар ажиллах төрийн албан хаагчдын судалгааг гарган 2020 оны 05 дугаар сарын 01 ний өдрийн 624 тоот албан бичгээр хүргүүлсэн.

Хэлтсийн нийт албан хаагчдад Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулиар 2020 оны 04 дүгээр сарын 30 ны өдөр сургалтыг цахим хэлбэрээр зохион байгуулсан.

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль, УБЕГ-ын даргын 2020 оны А/372 дугаар тушаалаар батлагдсан “Сонгогчдын нэрийн жагсаалт үйлдэх, сонгогч шилжих журам”-ыг улсын бүртгэгч нарт хүргүүлэн холбогдох эрх зүйн бусад актыг уншиж, судлан иргэний улсын бүртгэл болон сонгогчийн бүртгэл хөтлөхөд мөрдөж ажиллан аливаа ашиг сонирхлын зөрчлөөс ангид байж төрийн албан хаагчийн ёс зүйг чанд баримтлан ажиллахыг цаасан болон цахим хэлбэрээр анхааруулан зөвлөж мэдээллийг өгч ажилласан.

Чиглэлийн дагуу хийж гүйцэтгэсэн ажлын илтгэх хуудсыг хугацаанд нь буюу 2020 оны 05 дугаар сарын 05 ны өдрийн 642 тоот албан бичгээр УБЕГ-т хүргүүлсэн.

5.2020 оны 05 дугаар сарын 19 ны өдрийн 5/4911 тоот албан бичгээр ирүүлсэн чиглэлийн дагуу сонгуулийн хууль тогтоомжоор хүлээсэн үүргийн хэрэгжилтийг хангахад анхаарч ажиллан улсын бүртгэлийн байгууллагаас Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны ерөнхий төлөвлөгөөний цаг хугацааны дагуу холбогдох ажлуудыг хугацаанд нь хийж гүйцэтгэсэн. Үүнд:

- Сонгогчдын нэрийн жагсаалтыг хэвлэх бэлтгэл ажлыг урьдчилан ханган, хэвлэх үйл ажиллагааг 2020 оны 05 дугаар сарын 27 ны өдөр хэлтсийн №4 тоот өрөөнд нийт 10 хүний бүрэлдэхүүнтэйгээр хийж гүйцэтгэсэн бөгөөд хэвлэх үйл ажиллагаанд хэлтсийн дарга, хяналтын улсын байцаагч нар хяналт тавин ажиллаж, ямар нэг флаш, диск, тоног төхөөрөмжид хийж хуулж авах үйлдэл гаргахаас урьдчилан сэргийлж анхааруулга сануулга өгч ажилласан.

- Сонгогчдын нэрийн жагсаалтыг хэвлэх эрх авсан улсын бүртгэгч Н.Дарханцэцэг, Ё.Жумаа, Д.Ганцэцэг нар нь хэлтсийн №4 номерийн өрөөнд байрлах хяналтын улсын байцаагч Б.Хишгээ, Б.Цогзолмаа, улсын бүртгэгч С.Нямпэл нарын компьютерт өөрсдийн эрхийн дагуу программд нэвтэрч сонгогчдын нэрийн жагсаалтыг хэсэг тус бүрээр 3 хувь хэвлэх ажлыг 16:00 цагт эхлүүлэн 21:32 цагт дуусгасан.

- Сонгуулийн 19 дүгээр тойргийн 39-н хэсгийн сонгогчдын нэрийн жагсаалтыг тус бүр 3 хувь хэвлэж, хяналтын улсын байцаагч, улсын ахлах бүртгэгч, улсын бүртгэгч нар хэсэг тус бүрийн эхний дугаарын сонгогч, сүүлийн дугаарын сонгогч тус бүрээр нягтлаж хуудасны тоо, “Түр хасав” тэмдэглэгээтэй сонгогчийн тоог нэг бүрчлэн тоолж, тулган шалгаж, хэвлэсэн улсын

2020 оны үйл ажиллагааны тайлан

бүртгэгч албан хэрэгцээнд ашиглаж буй өөрийн тэмдэг, хэлтсийн тамгаар тус тус баталгаажуулсан.

- Нэрийн жагсаалтыг хэвлэх явцад программаас ямар нэг флаш диск тоног төхөөрөмжид хуулж авах үйлдэл гаргаагүй, программаас сонгогчдын нэрийн жагсаалтыг компьютерт хадгалсан эсэх, PDF файл хэлбэрээр хуулж авч үлдээсэн эсэхийг хяналтын улсын байцаагч, мэдээллийн технологийн ажилтан нар нягтлан шалгахад зөрчил гараагүй.

- Жагсаалтыг хэсэг тус бүрээр хавтаслан үдэж, хаяглан бэлтгэж нийт 117-н хавтас бүхий нэрийн жагсаалтыг хэлтсийн даргын өрөөнд байршуулан 00:45 цагт лацадсан.



- 2020 оны 05 дугаар сарын 28 ны өдөр ирүүлсэн СНЖ хүлээлгэн өгөх загварын дагуу актыг 2 хувь үйлдэн сум тус бүрийн сонгуулийн хороонд хэсгийн ахлагч, итгэмжлэгдсэн ажилтан нарыг байлцуулан сонгогчдын нэрсийн жагсаалтыг хүлээлгэн өгөх /актын нэг хувийг сумдын сонгуулийн хэсгийн хороонд, нэг хувийг хэлтэст авч үлдэх/ ажлыг тухайн өдрийн 09:00 - 16:20 цагийн хооронд хийж гүйцэтгэсэн.





Чиглэлийн дагуу хийж гүйцэтгэсэн ажлын илтгэх хуудсыг хугацаанд нь буюу 2020 оны 05 дугаар сарын 28 ны өдрийн 779 тоот албан бичгээр УБЕГ-ын ИУБГ-т хүргүүлсэн.

6.Улсын бүртгэлийн ерөнхий газрын 2020 оны 06 дугаар сарын 03 ны өдрийн 2/5447 тоот албан бичгээр ирүүлсэн чиглэлийн дагуу дараах ажлыг хийж гүйцэтгэсэн. Үүнд:

- Сонгуулийн үйл ажиллагаанд хэрэглэгдэх техник, тоног төхөөрөмж, бараа материалыг батлагдсан хуваарийн дагуу аймгийн Тагнуулын хэлтэс, Цагдаагийн газрын албан хаагчийн бүрэлдэхүүнтэйгээр татан авсан.

- Улсын бүртгэлийн байгууллагын итгэмжлэгдсэн ажилтныг гэрээнд заасан хугацаагаар хийж гүйцэтгэх үүрэгт ажлыг 2020 оны 06 дугаар сарын 02 ны өдрөөс эхлүүлж, хяналт тавин ажилласан.

- Сонгогчийн шилжилтийг хийхдээ ИУБГ-аас ирүүлсэн зөвлөмж, чиглэлийг мөрдөж хуулийн хугацаанд хийж гүйцэтгэсэн.

7. Сонгуулийн санал авах өдөр ирц бүртгэлийн мэдээг УБЕГ-ын БТДШГ-аас ирүүлсэн чиглэлийн дагуу тогтоосон цагуудад uyanga@burtgel.gov.mn цахим хаягаар тухай бүр шуурхай хүргүүлэн ажилласан.

8.УБЕГ-ын ИУБГ-аас 2020 оны 07 дугаар сарын 03 ны өдөр цахимаар ирүүлсэн чиглэлийн дагуу тус аймгийн сумдын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн сонгуулийн хэсгийн төв, нутаг дэвсгэрийг тогтоосон тухай тогтоолуудыг 2020 оны 05 дугаар сард хүлээн авч эх хувь мөн эсэх, тамга дарагдаж, гарын үсэг зурж баталгаажсан эсэхийг сайтар шалгаж, эх хувийг 2020 оны 05 дугаар сарын 29 ний өдрийн 787 тоот албан бичгээр УБЕГ-ын Иргэний улсын бүртгэлийн газарт хугацаанд нь хүргүүлсэн.

Иргэний улсын бүртгэлийн мэдээллийн санд эрх авсан 3-н улсын бүртгэгч 4-н сумын 40 сонгуулийн хэсэгт хамаарах санал авах байр буюу хэсгийн төв түүнд хамаарах 1827-н хаягийн мэдээллийг шивсэн.

9.УБЕГ-ын ИУБГ-аас 2020 оны 07 дугаар сарын 08 ны өдөр цахимаар ирүүлсэн чиглэлийн дагуу цахим хаягаар ирүүлсэн үүргийн дагуу дараах ажлыг хийж гүйцэтгэсэн. Үүнд:

- Санал авах байрны жагсаалтад бүртгэгдээгүй 24-н хаягийг тогтоолын дагуу мэдээллийн санд бүртгэсэн.

- Сонгогчдын нэрийн жагсаалтад хэсэг оноогдоогүй 87-н иргэнд хэсэг оноох ажлыг хийсэн.

- Тус аймгийн 4 сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн тогтоолоор зарласан 40-н сонгуулийн хэсэгт хамаарах санал авах байр буюу хэсгийн төв түүнд хамаарах нутаг дэвсгэрийг дахин нэг бүрчлэн нягтлан шалгасан.

10.Улсын бүртгэлийн ерөнхий газрын Иргэний улсын бүртгэлийн газрын 2020 оны 08 дугаар сарын 07 ны өдрийн 5/7130, Хяналт шалгалтын газрын 2020 оны 08 дугаар сарын 11 ний өдрийн 8/7215 тоот албан бичгүүдээр ирүүлсэн чиглэлийн дагуу дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн. Үүнд:

- Хууль тогтоомжийн хэрэгжилтийг ханган иргэний шилжилт хөдөлгөөний бүртгэлийг түр зогсоохтой холбогдуулан УБЕГ-аас ирүүлсэн тушаал, чиглэл, зөвлөмжийг тухай бүр нь сумдын улсын бүртгэгч нарт хүргүүлэн танилцуулж, хэрэгжүүлэн ажиллах талаар зөвлөмж, үүрэг даалгаврыг өгч ажилласан.

- 2020.06.25-2020.08.14 ний өдрийн хугацаанд шилжилт хөдөлгөөний бүртгэлд бүртгүүлсэн 996-н иргэний мэдээллийг холбогдох хууль тогтоомжид заасан хаяг нотлох баримт бичиг болон иргэний улсын бүртгэлийн цахим мэдээллийн санд нягтлан шалгасны дагуу бүртгэл хөтөлж, тухай бүр нь хяналтын улсын байцаагчаар хянуулсан.

- Улсын бүртгэгч нар шилжилт хөдөлгөөний бүртгэл хөтөлсөн ИУБ-22 маягыг хаягийг нотлох баримт бичгийн хамт өдөр бүр иргэн тус бүрээр PDF файл болгон хяналтын улсын байцаагчид хүлээлгэн өгч ажилласан.

- 2020 оны 8 дугаар сарын 14 ний өдрөөс өмнө шилжилт хөдөлгөөний бүртгэл хөтөлж, иргэний улсын бүртгэлийн цахим мэдээллийн санд бүртгэсэн төлөвтэй байсан иргэний мэдээллийг алдаагүй, үнэн зөв баталгаажуулах ажлыг улсын ахлах бүртгэгч болон эрх бүхий улсын бүртгэгч нар хийж гүйцэтгэсэн.

- 2020 оны 8 дугаар сарын 14 ний өдөр хөтөлсөн шилжилт хөдөлгөөний бүртгэлийг хяналтын улсын байцаагчаар хянуулж, тухайн өдрийн 24.00 цагийн дотор иргэний улсын бүртгэлийн цахим мэдээллийн санд баталгаажуулж дуусгасан.

- Шилжилт хөдөлгөөний бүртгэлийг иргэний улсын бүртгэлийн офлайн санд бүртгэсэн Орхон, Хонгор, Шарын гол сумдын улсын бүртгэгч нарыг тус өдөр 17.30 – 22.30 цагийн

2020 оны үйл ажиллагааны тайлан



ХАГААМ
ХЭВЭГСЭЭР ДЭГЭЭР
ҮЙЛЭГЭЙН 3 ТАНЦЭГЭД

АЙМАГ, НИЙСЛЭЛЭЙН ХУМ АЖЛАХЫН НЭГЭЭРХ АЖЛАХЫН ТӨСӨӨНӨМӨЛӨӨН АЖЛАХЫН
СОНГОГЧДИЙН ХЭЛТЭСНИЙ ХЭВЭГСЭЭР 2020 ОНЫ 09 ДҮГЭЭР САРЫН 07 НЫ ӨДРИЙН
5/7943 ТООТ АЛБАН БИЧИГ БОЛОН 5-Н УДААГИЙН ДОТООД АЛБАН БИЧГЭЭР ИРҮҮЛСЭН
ЧИГЛЭЛҮҮДИЙН ТАЙЛАН

№	Хийгэгчдийн нэр, асуула	Хугацаа	Хариуцагчдын нэв, хугацаа
1	Гуртгал, Сургалтын Формат, ханга догооноос хариуцаж үзүүлэх	18.00-18.10	А.Сүхбаатар, Д.Мөнх- Амгалан, Д.Мөнх- Амгалан, Д.Мөнх- Амгалан, Д.Мөнх- Амгалан
2	Аймаг, нийслэл, сум суурин байрмалын Төлөөлөгчдийн Хурлын үйлдвэр, үйлдвэр үйлдвэр, үйлдвэр, үйлдвэр үйлдвэр, үйлдвэр, үйлдвэр	18.10-18.30	З.Ганзориг, Ж.Сүхбаатар, Д.Мөнх-Амгалан
3	Урьдчилсан үйлдвэр, үйлдвэр үйлдвэр, үйлдвэр, үйлдвэр үйлдвэр, үйлдвэр, үйлдвэр	18.30-18.50	Н.Батбаяр, Д.Мөнх- Амгалан, Д.Мөнх- Амгалан
4	Урьдчилсан үйлдвэр, үйлдвэр үйлдвэр, үйлдвэр, үйлдвэр үйлдвэр, үйлдвэр, үйлдвэр	18.50-19.15	Т.Мөнх-Амгалан
5	Урьдчилсан үйлдвэр, үйлдвэр үйлдвэр, үйлдвэр, үйлдвэр үйлдвэр, үйлдвэр, үйлдвэр	19.15-19.30	З.Ганзориг, Ж.Сүхбаатар, Д.Мөнх-Амгалан



12. Дархан-Уул аймаг дахь Улсын бүртгэлийн хэлтэс нь Улсын бүртгэлийн ерөнхий газрын Иргэний улсын бүртгэлийн газраас ирүүлсэн 2020 оны 09 дүгээр сарын 07 ны өдрийн 5/7943 тоот албан бичиг болон 5-н удаагийн дотоод албан бичгээр ирүүлсэн чиглэлүүдийн дагуу дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн. Үүнд:

- Сонгогчдын нэрийн жагсаалтыг хэвлэх бэлтгэл ажлыг урьдчилан ханган, хэвлэх үйл ажиллагааг 2020 оны 09 дүгээр сарын 17 ны өдөр хуваарийн дагуу хэлтсийн №4 тоот өрөөнд нийт 8-н хүний бүрэлдэхүүнтэйгээр хийж гүйцэтгэсэн бөгөөд хэвлэх үйл ажиллагаанд хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч, хяналтын улсын байцаагч нар хяналт тавин ажиллаж, ямар нэг флаш, диск, тоног төхөөрөмжид хийж хуулж авах үйлдэл гаргахаас урьдчилан сэргийлж анхааруулга сануулга өгч ажиллалаа.

- Сонгогчдын нэрийн жагсаалтыг хэвлэх эрх авсан улсын бүртгэгч Н.Дарханцэцэг, Ё.Жумаа, Д.Ганцэцэг нар нь хэлтсийн №4 номерийн өрөөнд байрлах хяналтын улсын байцаагч

Б.Хишгээ, Б.Цогзолмаа, улсын бүртгэгч С.Нямпэл нарын компьютерт өөрсдийн эрхийн дагуу програмд нэвтэрч сонгогчдын нэрийн жагсаалтыг хэсэг тус бүрээр 2 хувь хэвлэх ажлыг 13:30 цагт эхлүүлэн 18:14 цагт дуусгасан.



- Сонгуулийн 40-н хэсгийн сонгогчдын нэрийн жагсаалтыг тус бүр 2 хувь хэвлэж, дууссаны дараа хяналтын улсын байцаагч, улсын ахлах бүртгэгч, улсын бүртгэгч нар хэсэг тус бүрийн эхний дугаарын сонгогч, сүүлийн дугаарын сонгогч тус бүрээр нягтлаж хуудасны тоо, сонгогчийн тоог нэг бүрчлэн тулган шалгаж, хэвлэсэн улсын бүртгэгч нар албан хэрэгцээнд ашиглаж буй өөрийн тэмдэг, хэлтсийн тамгаар тус тус баталгаажуулсан болно.

- 2020 оны 09 дүгээр сарын 17 ны өдөр сонгогчдын нэрийн жагсаалт хүлээлцэх акт, баталгааг тус бүр 2 хувь үйлдэн сум тус бүрийн сонгуулийн хорооны дарга, нарийн бичгийн дарга, гишүүдийг байлцуулан сонгогчдын нэрсийн жагсаалтыг хүлээлгэн өгөх ажлыг тухайн өдрийн 16:50 - 21:00 цагийн хооронд хийж гүйцэтгэсэн.



- Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 20.9.1-20.9.5 дахь хэсэг, “Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн сонгогчдын нэрийн жагсаалт үйлдэх, танилцуулах, хүргүүлэх журам”-ын 3.5 дахь хэсэгт заасны дагуу сонгогчдын нэрийн жагсаалтад тусгагдсан өөрчлөлтийн 12 лавлагааг хэвлэж хяналтын улсын байцаагчаар хянуулан баталгаажуулсан.

13. Улсын бүртгэлийн ерөнхий газраас ирүүлсэн чиглэл, хөтөлбөрийн дагуу сургалтын бэлтгэл ажлыг ханган тус хэлтсийн нийт албан хаагчид болон итгэмжлэгдсэн ажилтнаар томилогдсон Аймаг, нийслэл, сум дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн 40 хэсгийн хороонд ажиллах 44 итгэмжлэгдсэн ажилтнуудад холбогдох сургалтуудыг 2020 оны 10

дугаар сарын 07, 08-ны өдрүүдэд УБЕГ-ын Сургалтын багтай хамтран аймгийн Засаг даргын Тамгын газарт танхимаар амжилттай зохион байгуулан ажиллалаа.

14. Сонгуулийн санал авах өдөр ирц бүртгэлийн мэдээг УБЕГ-ын БТДШГ-аас ирүүлсэн чиглэлийн дагуу тогтоосон цагуудад uyanga@burtgel.gov.mn цахим хаягаар тухай бүр шуурхай хүргүүлэн ажилласан.



15. Улсын бүртгэлийн ерөнхий газраас ирүүлсэн чиглэл, зөвлөмжийн дагуу “Нэмэлт санал хураалт” явуулахтай холбоотойгоор дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ. Үүнд:

- Аймгийн Сонгуулийн хорооны “Нэмэлт санал хураалт явуулах тухай” 2020 оны 10 дугаар сарын 16 ны өдрийн 39, “Нэмэлт санал хураалтын цагт өөрчлөлт оруулах тухай” 10 дугаар сарын 24 ний өдрийн 42 дугаар тогтоолуудыг тус тус УБЕГ-ын Иргэний улсын бүртгэлийн газар, Бодлого төлөвлөлт, дүн шинжилгээний газруудад b.narangerel@burtgel.gov.mn, uyanga@burtgel.gov.mn цахим хаягуудаар хүргүүлсэн.

- Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны ээлжит сонгуулиар нэмэлт хураалт явуулах нөхцөл байдал үүссэн сум, дүүргийн иргэний шилжилт хөдөлгөөнийг тухайн нэмэлт санал хураалт явагдаж дуустал түр хугацаагаар зогсоосон тухай УБЕГ-ын даргын 2020 оны А/1389 тоот тушаалын хэрэгжилтийг ханган ажилласан.

- УБЕГ-ын МТГ-аас цахим хаягаар ирүүлсэн чиглэлийн дагуу 2020.10.22 ны өдөр Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн нэмэлт санал хураалтын өдөр 7-1-20 дугаар хэсгийн хороонд ажиллах 2 итгэмжлэгдсэн ажилтанд “Сонгогчдын нэрийн

жагсаалтын цахим сангаас сонгогчийн хувийн мэдээллийг нягтлан шалгах программ” сэдвээр сургалтыг хийсэн.



- УБЕГ-ын МТГ-аас цахим хаягаар ирүүлсэн чиглэлийн дагуу 2020.10.23 ны өдрийн 10.00 цагт аймгийн Тагнуулын хэлтэст Д.Мөнхсан, Б.Хишгээ нарын хамт очиж тагнуулын ажилтан Батсайханы хяналтанд тухайн сонгуулийн хэсгийн хорооны техник, тоног төхөөрөмжийн бүрэн бүтэн байдлын нягтлан шалгасан.

- Мэдээлэл, технологийн газраас боловсруулсан ирц бүртгэлийн программын гарын авлага, хичээлийг хэвлэн итгэмлэгдсэн ажилтнуудад сайтар уншиж танилцахыг анхааруулж сануулсан.

- Ирц бүртгэлийн мэдээг УБЕГ-ын БТДШГ-аас ирүүлсэн чиглэлийн дагуу 2020.10.25 ны өдөр тогтоосон цагуудад /11, 16, 20/ uyanga@burtgel.gov.mn цахим хаягаар тухай бүр шуурхай хүргүүлэн ажилласан. Тухайн өдөр гомдол гаргасан иргэн байхгүй.

- Нэмэлт санал хураах ажиллагаа дууссаны дараа 21.00 цагт сонгогчийн ирц бүртгэлийн тоног төхөөрөмжийг аймгийн Тагнуулийн хэлтэст хүлээн авах ажлыг зохион байгуулж, Иргэний улсын бүртгэлийн газрын улсын ахлах бүртгэгч Б.Нарангэрэлд утсаар ямар нэгэн алдаа зөрчилгүйгээр тухайн өдрийн ажил дууссан тухай мэдээлсэн.

- Тус өдөр 17:40–17:46, 19:03–19:07 цагуудад тухайн хэсгийн хороо байрласан нутаг дэвсгэрт цахилгааны гэмтэл гарч нийт 10 минут тог тасарсан. Тухайн цагт хэсгийн хороо цахилгааны эх үүсвэр болох мотор ажиллуулж санал хураах ажлыг хэвийн зохион байгуулсан.

16.УБЕГ-ын ИУБГ-ын 2020 оны 11 дүгээр сарын 10 ны өдрийн 5/9906 тоот албан бичгээр ирүүлсэн чиглэлийн дагуу иргэний улсын бүртгэлийн цахим мэдээллийн санд нэвтрэх эрхийг нээлгэн ажиллаж байна.

17. УБЕГ-ын ИУБГ-ын 2020 оны 12 дугаар сарын 07 ны өдрийн 161 тоот дотоод албан бичгээр ирүүлсэн чиглэлийн дагуу “Монгол Улсын үндэсний энгийн гадаад паспорт олгох,

эзэмших, хадгалах журам"-ын төсөлд тусгах саналыг хугацаанд нь b.narangerel@burtgel.gov.mn цахим хаягаар хүргүүлсэн.

Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн газраас ирүүлсэн зөвлөмж, чиглэл:

1.Мэдээллийн сангийн алдаа зөрчлийг арилгах тухай 2019.12.04-ний өдрийн 7/9562 дугаартай чиглэлийн дагуу Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн цахим систем /EPRS/-д бүртгэлийн үйлчилгээний төрлийг Газраас бусад үл хөдлөх эд хөрөнгийг “Төрөөс хувьчилсан газрын өмчлөх эрхийг анх удаа баталгаажуулах” гэж буруу сонгосон-138, Төрөөс хувьчилсан газрын өмчлөх эрхийг анх удаа бүртгэх төрлийг Төрөөс хувьчилсан орон сууц өмчлөх эрхийг анх удаа бүртгэх төрлөөр сонгосон-4, Эд хөрөнгийн төрөл буруу сонгосон -1 нийт 143-н бүртгэлийг шалгаж хяналтын улсын байцаагчийн №1213, №1242 тоот дүгнэлтийн дагуу мэдээллийн санд зөрчлийг арилгасан.

2.ЭХЭУБГ-ын “Шаардах эрх бүртгүүлэх тухай” 2020.01.15-ны 7/388 дугаартай чиглэлийн дагуу Төрийн банк, “МИК ОССК” ХХК-аас ирүүлсэн 20-н шаардах эрхийн мэдүүлгийг хүлээн авч 18-г бүртгэн, 2 бүртгэлийг хууль хяналтын байгууллагаас тусгай тэмдэглэл бүртгэлтэй байсан тул бүртгэхээс татгалзан хариуг холбогдох газарт хүргүүлсэн.

3.Захиргаа, эрх зүйн хэлтсийн 2020.02.17-ны өдрийн 3-1/1596 дугаартай албан тоотоор ирүүлсэн “Хууль хяналтын байгууллага болон шүүхээр шийдвэрлэгдэж байгаа хэрэг маргааны судалгаа”-г 2017-2019 оноор эрэмбэлэн жагсаалтаар хүргүүлсэн.

4.Мэдээллийн санд нэгж талбарын дугаар оруулаагүй бүртгэлийн зөрчлийг арилгах 2020.02.28-ны өдрийн 7/1960, дугаартай чиглэлийн дагуу нэгж талбарын дугаарыг мэдээлэлд тусгаагүй 290-н бүртгэлийг шалгаж 1997-2015 онд ашиглалтанд орсон төрөөс хувьчлагдсан 63-н орон сууцны бүртгэлийн нэгж талбарын дугаарыг аймгийн ГХБХБГ-аас албан тоотоор авч, үлдсэн 227-н нэгж талбарын дугаарыг хувийн хэрэгт хавсаргасан кадастрын зургаас авч хяналтын улсын байцаагчаар зөрчлийг арилгуулах тухай дүгнэлт гаргуулан зөрчлийг арилган ажилласан.

5.УБЕГ-ын Захиргаа, эрхзүйн хэлтсийн 2020.04.27-ны өдрийн 3/4026 дугаартай албан бичгээр ирүүлсэн” УБЕГ-т холбогдох хууль хяналт болон шүүх байгууллагаар хэрэг маргааны явцад хяналт тавих журам"-ын төсөлд оруулах саналыг a.khulan@burtgel.gov.mn цахим хаягаар болон цаасан хэлбэрээр хугацаанд нь хүргүүлсэн.

6.УБЕГ-ын даргын “ Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн талаарх зарим арга хэмжээний тухай” 2020.08.11-ны өдрийн А/1172 дугаар тушаал гарсантай холбогдуулан Хяналт, шалгалтын газрын 2020 оны 8/7219 дугаартай чиглэлд хаяж, үрэгдүүлсэн гэрчилгээг хүчингүйд тооцсон дүгнэлт гаргаж, шийдвэрлэх эрхийг хэрэгжүүлэхийг улсын бүртгэлийн байгууллагын орон нутаг дахь Улсын бүртгэлийн хэлтсийн хяналтын улсын байцаагч нарт

зөвшөөрсөн бөгөөд тайлангийн хугацаанд хяналтын улсын байцаагчийн дүгнэлтээр 12 гэрчилгээг дахин олгосон.

7.УБЕГ-ын даргын 2020.08.19-ны өдрийн 1/7415 дугаартай албан бичгээр ирүүлсэн "Хилийн цэс зөрчиж газар өмчлүүлсэн, хаяг, улсын бүртгэлийн дугаар буруу бүртгэгдсэн судалгаа"-ны хариуг албан бичгээр хүргүүлсэн.

8.УБЕГ-ын Эд хөрөнгийн эрхийн улсын бүтгэлийн газрын даргын 57 дугаартай дотоод албан бичгээр ирүүлсэн чиглэлийн дагуу аймгийн хэмжээний дуусаагүй барилгын судалгааг гарган e.oyuntsetseg@burtgel.gov.mn хаягаар цахим болон цаасан хэлбэрээр хүргүүлэн ажилласан.

Хяналт шалгалтын газраас ирүүлсэн зөвлөмж, чиглэл:

1.2020 оны 01 сарын 16-ны өдрийн 8/408 тоот албан бичгээр ирүүлсэн чиглэлийн дагуу хяналт шалгалтын статистик мэдээг загварын дагуу сар бүр хугацаанд нь гаргаж хэвшүүлсэн.

2.2020 оны 01 дүгээр сарын 16-ны өдрийн 8/409 тоот албан бичгээр ирүүлсэн чиглэлийн дагуу төлөвлөгөөт бус шалгалтын хүрээний дагуу дараах ажлыг хийж гүйцэтгэсэн. Үүнд

- Иргэний шилжилт хөдөлгөөнийг 2020 оны 02 дугаар сарын 01-ний өдрөөс зогсоосонтой холбогдуулан 2019 оны 12 сарын 10-ны өдрөөс 2020 оны 01 сарын 31-ний өдрийн байдлаар өөр аймаг, хотоос ирсэн 222, сумаас сум хооронд 39, баг хооронд 368 нийт 629 шилжилт хөдөлгөөний бүртгэлийг иргэний улсын бүртгэлийн цахим санд үнэн зөв, бүрэн бүртгэгдэж баталгаажсан эсэх, Монгол улсын нутаг дэвсгэрт иргэн шилжин суурьших хөдөлгөөнийг бүртгэх, мэдээлэх журмын 2 дугаар зүйлийн 2.1, 2.2-д заасан хангалттай нотлох баримт байгаа эсэхэд хяналт шалгалт хийхэд холбогдох хууль тогтоомжийг зөрчсөн зөрчил илрээгүй болно.

- Иргэний шилжилт хөдөлгөөний бүртгэлд 2020 оны 01 сарын 09-ний өдрөөс хяналт тавьсан тайланг долоо хоног бүрийн 4 дэх өдрөөр тасалбар болгон хүргүүлэн ажилласан.

3.2020 оны 04 дүгээр сарын 08-ны өдрийн 8/3778 тоот албан бичгээр ирүүлсэн чиглэлийн дагуу дараах ажлыг хийж гүйцэтгэсэн. Үүнд:

- Иргэний шилжилт хөдөлгөөний бүртгэлийн 2017 оны 19 бүртгэлийн дэвтрийн 5427 бүртгэл, 2018 оны 22 бүртгэлийн дэвтрийн 6538 бүртгэл, 2019 оны 12 бүртгэлийн дэвтрийн 3283 бүртгэлийг иргэний улсын бүртгэлийн цахим санд нэг бүрчлэн тулган шалгаж үнэн зөв, бүрэн, хууль тогтоомжийн дагуу бүртгэгдсэн эсэхэд хяналт тавьж, шалгалт хийхэд илэрсэн алдаа зөрчил илрээгүй болно.

- Хяналтын улсын байцаагч нар Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1 дэх хэсэгт заасан хугацаанд иргэний засаг захиргааны нэг нэгжээс нөгөө нэгжид шилжин суурьших хөдөлгөөний бүртгэлд байнгын хяналт тавьж ажилласан.

4.2020 оны 05 дугаар сарын 07-ны өдрийн 8/4402 тоот албан бичгээр ирүүлсэн чиглэлийн дагуу Иргэний улсын бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлд заасан биеийн давхцахгүй

өгөгдлийн бүртгэлтэй холбоотой тухайлбал биеийн давхцахгүй өгөгдлийн бүртгэлд 2 ба түүнээс дээш удаа бүртгэгдсэн зөрчлийг хууль тогтоомжийн дагуу тухайн нэгжийн хяналтын улсын байцаагч нар шалган шийдвэрлэж байхыг мэдэгдсэн. Тайлант хугацаанд иргэдээс тус хэлтэст хандаж гаргасан биеийн давхцахгүй өгөгдлийн бүртгэлд хаяг зөрүүтэй бүртгүүлсэн 2 өргөдөл, улсын бүртгэгч нараас гаргасан овог, нэрний үсгийн алдааг залруулах тухай 6 хүсэлтийг хүлээн авч холбогдох бүртгэлийг шалган 8 дүгнэлт гаргаж зөрчлийг арилгуулсан байна. Хурууны хээ давхардсан зөрчил одоогоор илрээгүй байна .

5.2020 оны 05 дугаар сарын 18-ны өдрийн 2/4861 дугаартай албан бичгээр ирүүлсэн чиглэлийн дагуу 2019 оны 12 дугаар сарын 10-ны өдрөөс 2020 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийг дуустал хугацаанд бүртгэсэн шилжилт хөдөлгөөний 1139 бүртгэлийг сумдын улсын бүртгэгч нарын хамт дахин нягтлан шалгах ажлыг хийж гүйцэтгэсэн.

6.2020 оны 05 сарын 28-ны өдрийн 8/5265 тоот албан бичгээр ирүүлсэн чиглэлийн дагуу дараах ажлыг хийж гүйцэтгэсэн. Үүнд:

- 2020 оны 06 дугаар сарын 04-ний өдрөөс эхлэн 2020 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн ажлын цагт багтаан нийт 765 сонгогчийн шилжилтийг хүсэлт, нотлох баримтыг үндэслэн бүртгэсэн эсэх сонгогчдын нэрийн жагсаалтанд өөрчлөлт оруулах 28 лавлагааг тус тус хуулийн дагуу үнэн зөв хэвлэсэн эсэхэд хяналт тавьж тэмдэглэн хөтлөн мэдээг ирүүлсэн загварын дагуу хугацаанд нь Хяналт шалгалтын газарт хүргүүлэн ажилласан.

7.Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хуулийн дагуу “Иргэний шилжилт хөдөлгөөний бүртгэлийг түр зогсоох тухай” УБЕГ-ын даргын А/1168 дугаар тушаал гарсантай холбогдуулан Хяналт шалгалтын газраас ирүүлсэн 2020 оны 06 дугаар сарын 26-ны өдрийн 8/6147 тоот албан бичиг, 08 дугаар сарын 11-ний өдрийн 8/7215 тоот албан бичгээр тус тус ирүүлсэн чиглэлийн хүрээнд 2020 оны 06 дугаар сарын 25-ны өдрөөс 08 дугаар сарын 15-ны өдрийг хүртэлх хугацаанд тус аймагт хөтөлсөн иргэний шилжилт хөдөлгөөний бүртгэлийн үйл ажиллагаанд өдөр тутам хяналт тавьж дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн.

Тус хугацаанд 4-н суманд нийт 996-н шилжин ирсний бүртгэл хөтөлж, мэдээллийн санд баталгаажуулсан байх бөгөөд Хяналтын улсын байцаагч нар бүртгэлийн эх нотлох баримтыг бүрэн гүйцэд бүрдүүлэн авсан эсэх, нотлох баримтад авагдсан үл хөдлөх эд хөрөнгийн өмчлөх, эзэмших эрхийн гэрчилгээн дэх хаяг шилжин ирж байгаа иргэний оршин суух хаягтай тохирсон, өмчлөгч, эзэмшигчийн зөвшөөрөлд шилжин ирж байгаа иргэний овог нэрийг тусгасан эсэх, ИУБ-22 маягтад иргэний гарын үсэг зуруулсан эсэх, иргэний улсын бүртгэлийн цахим мэдээллийн санд мэдээллийг алдаагүй үнэн зөв тусгасан эсэх зэргээр бүртгэлд нэг бүрчлэн хяналт тавьж ажиллалаа. Үүнд:

- Үл хөдлөх эд хөрөнгийн гэрчилгээ болон өмчлөгчийн зөвшөөрөл, холбогдох гэрээ хэлцэл хууль тогтоомжид нийцсэн эсэхэд байнгын хяналт тавьж, зөвлөгөө мэдээллийг тогтмол өгч ажилласан.

- Чиглэлийн дагуу 7 хоног бүрийн эхний өдөр хяналт тавьсан тухай товч тайланг hyanalт@burtgel.gov.mn цахим хаягаар хүргүүлж, УБЕГ-дотоод сүлжээний 07.hyanalt гэсэн дундын хавтаст улсын бүртгэгч нараас нотлох баримтуудаа иргэний регистрийн дугаараар файл үүсгэн скайнердаж бүрэн гүйцэд оруулж байгаа эсэхэд тогтмол хяналт тавьж ажилласан.

- Аймгийн хэмжээнд дээр дурдсан хугацаанд шилжилт хөдөлгөөний бүртгэлийн нийт 996 бүртгэл хөтөлснөөс Орхон суманд 21, Хонгор суманд 28, Шарын гол суманд 50, Дархан суманд 897 бүртгэл тус тус хөтөлсөн байна. Үүнээс. 118 иргэн Улаанбаатар хотоос, 285 өөр бусад аймгаас шилжин ирсэн, сум хооронд 72, баг хооронд иргэн 521 иргэн тус тус шилжиж иргэний шилжилт хөдөлгөөний бүртгэлд бүртгүүлсэн байна. Цахим мэдээллийн санд баталгаажуулсан бүртгэлийн тоо дүнг бүртгэлийн дэвтэртэй тулгаж сум бүрээр судалгаа мэдээг гарган Дархан шилжилт хөдөлгөөн-2020.08.14 нэртэй файлыг УБЕГ-дотоод сүлжээний 07.hyanalt гэсэн дундын хавтаст байршуулсан.

- УБЕГ-ын Иргэний бүртгэлийн улсын бүртгэлийн газраас ирүүлсэн чиглэлийн дагуу иргэний улсын бүртгэлийн тасгийн дарга бөгөөд улсын ахлах бүртгэгчтэй хамтран шилжилт хөдөлгөөний бүртгэлд хяналт тавьж 2020 оны 08 дугаар сарын 14-ний өдрийн ажлын цагт багтаан бүртгэлийг дуусгаж улсын бүртгэгч нарын бүртгэлийг дэвтэртэй тулган хаасан тухай тэмдэглэгээг хийж, 12 дэвтэр, нийт үлдэгдэл 1063 ш ИУБ-22 маягтыг бүртгэн акт үйлдэж, хэлтсийн даргын өрөөнд сейфэнд хадгалуулан лацдах ажлыг хийж гүйцэтгэсэн.

8.УБЕГ-ын даргын 2020 оны 08 дугаар сарын 11-ний өдрийн А /1172 дугаар тушаалаар Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн гэрчилгээг хаяж үрэгдүүлсэн тохиолдолд хяналтын улсын байцаагчийн дүгнэлтээр гэрчилгээг хүчингүйд тооцож байхаар шийдвэрлэсний дагуу Хяналт шалгалтын газраас 2020.08.11 ний өдрийн 8/7219 дугаартай албан бичгээр ирүүлсэн чиглэлийг мөрдлөг болгон хэрэгжүүлж тайлант хугацаанд нийт 15 иргэний гаргасан мэдүүлэг, холбогдох нотлох баримтыг хүлээн авч шалган, гэрчилгээг хүчингүйд тооцох тухай 15 дүгнэлт үйлдэж эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тасагт шилжүүлэн хяналт тавьж ажилласан байна.

9.Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2020 оны 09 дүгээр сарын 11-ний өдрийн А/1321 дүгээр тушаалаар баталсан удирдамжийн дагуу тус аймаг дахь Улсын бүртгэлийн хэлтсийн үйл ажиллагаанд төлөвлөгөөт шалгалт хийж, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн үйл ажиллагаанд илэрсэн алдаа зөрчлийн талаарх Хяналтын улсын ахлах байцаагчийн 2020

оны 05 дугаартай мэдэгдэл, 30 дугаартай албан шаардлагыг тус тус хүлээн авч дараах арга хэмжээг авч ажиллалаа.

- Хэлтсийн хурлыг зохион байгуулж нийт албан хаагчдад улсын байцаагчийн мэдэгдэл, албан шаардлагыг танилцуулан, мэдэгдэлд дурдсан зөвлөмжүүдийг нэг бүрчлэн уншиж анхааруулан, цаашид гаргасан алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх, удаа дараа зөрчил гаргасан тохиолдолд хариуцлага тооцож ажиллахыг анхаарч, ажилдаа хариуцлагатай хандах, бүртгэлийн үйл ажиллагаанд хууль тогтоомжийг чанд мөрдөж ажиллахыг үүрэг болгосон.

- Хэлтсийн дарга, тасгийн дарга бөгөөд улсын ахлах бүртгэгч, хяналтын улсын байцаагч нараас албан хаагчдыг мэргэжил арга зүйн удирдлагаар хангах, бүртгэл хөтлөхөд эргэлзээтэй тодорхойгүй, шийдвэрлэхэд хүндрэлтэй байгаа асуудлаар хэлэлцэж, нэг мөр ойлголттойгоор хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, мөрдөж ажиллах зорилгоор бүртгэгч бүртэй нэг бүрчлэн уулзах, ярилцах ажлыг зохион байгуулж эхлүүлсэн. Үүнд иргэний улсын 2 бүртгэгчид тусгайлан мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажиллалаа.

- Зөрчил гаргасан улсын бүртгэгч нарт зөрчлийн тэмдэглэлийн дагуу илэрсэн зөрчлийг яаралтай арилгуулахыг, түүнд хяналт тавьж ажиллахыг хяналтын улсын байцаагч, улсын бүртгэгч нарт үүрэг болгосон. Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн 5-н бүртгэгчийн хөтөлсөн 34-н бүртгэлийн зөрчлөөс цахим мэдээллийн санд үйлчилгээний төрөл, төлөв буруу сонгосон 17-н бүртгэлийн зөрчлийг хяналтын улсын байцаагчийн дүгнэлтээр арилгуулан, улсын бүртгэгч нар 7-н зөрчлийг арилгаж, үлдсэн 9-н зөрчлийг арилгуулахаар холбогдох иргэнд мэдэгдэх, хариу тайлбар мэдээлэл авах арга хэмжээг эхлүүлсэн боловч улс орны хэмжээнд гарсан нөхцөл байдлаас шалтгаалан шийдвэрлэж дуусаагүй байгаа тул хөл хорио цуцлагдаж хэвийн горимоор ажилласан тохиолдолд зөрчлийг арилгуулан хариу мэдэгдэх болно. 1 зөрчил буюу эрхийн улсын бүртгэлийн Ү-2003009193 дугаарт тусгай тэмдэглэл бүртгэгдээгүй байна.

- Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тасгийн архивчид нотлох баримтыг хувийн хэрэгт зөв байршуулах, архивын баримтын ашиглалт, хадгалалт, хамгаалалтыг сайжруулан холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг бүрэн хангуулж ажиллахыг үүрэг болгож анхааруулсан.

- Иргэний улсын бүртгэлийн үйл ажиллагаанд бүртгэлийн үнэ хураамж төлүүлээгүй 17 зөрчлийг арилгуулах арга хэмжээ авч, бүртгэл хөтлөлт, нотлох баримтын бүрдлийг хангуулан хууль тогтоомжийг чанд мөрдөж, хариуцлагатай ажиллахыг анхааруулан бусад улсын бүртгэгч нарт мөн анхааруулж сануулсан.

- Хяналтын улсын байцаагч нарт дотоод хяналт шалгалтын ажлыг сайжруулж, бүртгэгч нарын бүртгэл хөтлөлтийг тогтмол шалгаж илэрсэн зөрчлийг тухай бүрт нь арилгуулах, алдаа зөрчлийг хэрхэн шийдвэрлэсэн, авах арга хэмжээний санал байгаа эсэхийг 14 хоног тутамд Даргын Зөвлөлд танилцуулж байхыг үүрэг болгосон. Мэдэгдэлд дурдсан арга хэмжээ, зөвлөмжийг цаашид хэрэгжүүлэх, илэрсэн алдаа зөрчлийг давтан гаргуулахгүй байх зорилгоор хяналт шалгалтыг эрчимжүүлэн эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн цахим мэдээллийн санд мэдээлэл алдаатай оруулсан, нотлох баримтыг сольж цахимжуулсан 2 зөрчил илэрснийг дүгнэлт гарган залруулах арга хэмжээ авч, бүртгэгчид хатуу анхааруулан, бүртгэгч бүрээр алдааны тэмдэглэл хөтлөн ажиллаж байна.

-“Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн хувийн хэргийн эх нотлох баримтыг цахим бүртгэлтэй тулгаж тоолох тухай” хэлтсийн даргын 2020 оны 02 дугаар сарын 05-ны өдрийн А/02 дугаар тушаалын хэрэгжилтийг хангуулах хүрээнд хувийн хэргийн мэдээллийг цахим санд тулгахад илэрч байгаа зөрчлийг арилгуулах ажлыг эрчимжүүлэн хяналтын улсын байцаагчийн 11-н дүгнэлтийг нөхөн гаргуулж зөрчлийг арилгах арга хэмжээ авсан.

Бусад чиглэл, зөвлөмж:

1.УБЕГ-ын Тамгын газрын 2020 оны 01 дүгээр сарын 30 ны өдрийн 3/965 тоот албан бичгээр ирүүлсэн чиглэлийн хэрэгжилтийг ханган албан хаагчид ТЖАХ-ын гүйцэтгэлийн төлөвлөгөө, биелэлтийг хуулийн хугацаанд тайлагнаж хэвшсэн.

2.УБЕГ-ын ИУБГ-аас 1 дүгээр улиралд цахимаар ирүүлсэн чиглэлийн дагуу хэлтсийн нийт албан хаагчид Улсын бүртгэлийн багц хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан онлайн-аар авсан саналд бүрэн хамрагдсан.

3.УБЕГ-ын Тамгын газраас ирүүлсэн чиглэлийн дагуу “Улсын бүртгэлийн ерөнхий газрын Хөдөлмөрийн дотоод журам”-д өөрчлөлт оруулах саналыг албан хаагчдаас авч нэгтгэн хүргүүлсэн.

4.УБЕГ-ын Тамгын газраас ирүүлсэн чиглэлийн дагуу “Орон нутгийн бүртгэлийн байгууллагын дүрэм”-д өөрчлөлт оруулах саналыг хүргүүлэн ажилласан.

5.УБЕГ-ын Тамгын газраас ирүүлсэн чиглэлийн дагуу Хэрэглэгчийн эрхийг хамгаалах өдрийг сурталчилан ажиллаж холбогдох тайланг хугацаанд нь хүргүүлсэн.

6.УБЕГгазраас 2 дугаар улиралд цахимаар ирүүлсэн чиглэлийн дагуу “Улсын бүртгэлийн цахим мэдээллийн санг ашиглах, түүний хадгалалт, хамгаалалт, нууцлалын аюулгүй байдлын журам”-ын төсөлд холбогдох саналыг хүргүүлэн ажилласан.

7.УБЕГ-ын УБНАГ-аас ирүүлсэн чиглэлийн дагуу 2 дугаар улиралд “Улсын бүртгэлийн салбарын үйл ажиллагааны явцад бий болсон баримт бичгийн хадгалах хугацааны жагсаалт”-д өөрчлөлт оруулах саналыг t.baigalmaa@burtgel.gov.mn цахим хаягаар болон цаасан хэлбэрээр хугацаанд хүргүүлсэн.

8.УБЕГ-ын Тамгын газрын 2020 оны 10 дугаар сарын 14 ний өдрийн 114 тоот дотоод албан бичгээр ирүүлсэн чиглэлийн дагуу УБЕГ-ын даргын 2020.10.14 ны өдрийн 1/9085 тоот албан бичгээр өгсөн “Үүрэг, чиглэл”-ийг хэлтсийн нийт албан хаагчдад танилцуулж, гарын үсгээр баталгаажуулсан.

9.УБЕГ-ын Тамгын газрын 2020 оны 10 дугаар сарын 23 ны өдрийн 3/9380 тоот албан бичгээр ирүүлсэн чиглэлийн дагуу улсын бүртгэлийн цахим мэдээллийн сангийн системд нэтрэх эрх /нээх, хаах, админ эрх/-тэй холбоотой асуудлыг чиглэлийн газруудад албан бичгээр хандан шийдвэрлүүлэн ажилласан.

10.УБЕГ-ын Бодлого төлөвлөлт, дүн шинжилгээний газрын 2020 оны 10 дугаар сарын 23 ны өдрийн 9/9378 тоот албан бичгээр ирүүлсэн зөвлөмжийн биелэлтийг хангаж ажилласан.

11.УБЕГ-ын Санхүү төлөвлөлтийн газрын 2020 оны 11 дүгээр сарын 03 ны өдрийн 4/9696 тоот албан бичгээр ирүүлсэн чиглэлийн дагуу сонгуулийн зардлыг гаргаж ажилласан.

ХОЁР. ИРГЭНИЙ УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЧИГЛЭЛЭЭР:

Тайлангийн хугацаанд иргэний улсын бүртгэлийн мэдээллийн санд бүртгэлийн мэдээлэл нь огт тусгагдаагүй болон мэдээлэл нь дутуу, алдаатай тусгагдсан бүртгэлийг бүртгэлийн дэвтэр, холбогдох маягт, мэдээлэл удирдах систем болон хувийн хэргээс шалгаж 371 бүртгэлийн зөрчлийг арилгуулахаар ИУБГ-т албан бичгээр тухай бүр нь хүргүүлэн ажиллаж зөрчлийг 100 хувь арилгуулсан.


Тайлангийн хугацаанд огт цахим үнэмлэх аваагүй 14, 16 нас хүрсэн 1292 иргэнийг иргэний шинэчилсэн бүртгэлд хамруулж иргэний цахим үнэмлэхжүүлсэн. Анх удаа болон, 25, 45 насны сунгалт, хаяж үрэгдүүлэн дахин авах хүсэлт гаргасан зэрэг нийт 4697 иргэний цахим үнэмлэхний мэдээллийг иргэний улсын бүртгэлийн мэдээллийн санд тусгаж, баталгаажуулан үнэмлэхжүүлсэн.



2018-2020 оны иргэний үнэмлэхний тоог харьцуулахад жил дараалан иргэний үнэмлэхийн захиалга ялангуяа дахин олголтын бүртгэл харьцангуй буурсан үзүүлэлттэй харагдаж байна. Энэ нь Монгол Улсын Зөрчлийн тухай хууль батлагдаж хэрэгжиж байгаатай холбоотойгоор иргэний үнэмлэхний хугацаа хэтэрсэн болон хаяж үрэгдүүлсэн зөрчил буурсантай холбоотой юм.


Үндэсний энгийн гадаад паспорт шинээр 1374-н, сум, баг хоорондын хаягийн хөдөлгөөн 2044-н иргэнд хийж, өөр аймаг, нийслэлээс шилжин ирсний 1373-н бүртгэлийг хөтөлсөн байна.

Тайлангийн хугацаанд үндэсний энгийн E серийн гадаад паспорт захиалгын бүртгэлийг графикаар харуулбал:



Нийт хүсэлт гаргасан 1374-н иргэний материалыг хүлээн авч Улсын бүртгэлийн ерөнхий газрын Иргэний улсын бүртгэлийн газарт тухай бүр нь албан бичгээр хүргүүлэн ажилласан.


/сүүлийн 3 жилийн байдлаар харуулбал/



Сумдаас ирүүлсэн болон хэлтсийн иргэний улсын бүртгэлийн 15964 ИУБ маягтыг нягтлан шалгаж цахим санд шивж, баталгаажуулан журмын дагуу холбогдох тоон мэдээ, тайланг 14 хоног, сар, улирлаар гарган хугацаанд нь УБЕГ-ын ИУБГ-т хүргүүлж байгаа бөгөөд сар бүр ИУБ маягтуудын “А” талыг ИУБГ, УБНАГ-т шилжүүлэн ажилласан.

Шүүхийн шийдвэр болон хяналтын улсын байцаагчийн дүгнэлтээр 15 иргэний регистрийн дугаарыг өөрчилж ИУБ маягтыг холбогдох журмын дагуу хийн ИУБГ-т хүргүүлэн цахим санд өөрчлөлтийг тусгуулан холбогдох бичиг баримтыг сольж олгосон.

Тайлангийн хугацаанд иргэний улсын бүртгэлийн чиглэлээр нийт 15964 бүртгэл хийсэн бөгөөд үүнийг графикаар үзүүлвэл:



Иргэний улсын бүртгэлийн тухай хуулийн 5.6-д “ Үрчилсний, овог эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр өөрчилсний, шилжилт хөдөлгөөний, Монгол улсын харьяат болсон, харьяатаас гарсан, иргэний харьяаллаа сэргээн тогтоосны бүртгэлээс бусад иргэний улсын бүртгэлийг засаг захиргааны нэгжийн харьяалал харгалзахгүй бүртгэнэ.” гэсний дагуу тус аймгийн өөр, аймаг нийслэлд түр оршин сууж байгаа иргэд тухайн орон нутгийн бүртгэлийн байгууллагаас бүртгэлийн үйлчилгээ авч байгаа болон шилжилт хөдөлгөөний бүртгэлийг 1 талд нь буюу зөвхөн шилжин ирсний бүртгэлийг хөтөлж байгаатай холбоотойгоор

- Гэрлэсний бүртгэл
- Гэрлэлт дуусгавар болсны бүртгэл
- Нас барсны бүртгэл
- Иргэний үнэмлэхийн бүртгэл
- Гадаадад зорчих эрхийн бүртгэл
- Биеийн давхцахгүй өгөгдлийн бүртгэлийн үйлчилгээ тус тус буурсан үзүүлэлттэй байна.

Иргэний улсын бүртгэлийн тухай хууль /шинэчилсэн найруулга/ хэрэгжиж эхэлснээс хойш 2019 оны жилийн эцсийн байдлаар 1924, 2020 оны жилийн эцсийн байдлаар 1188 бүртгэлийг харьяалал харгалзахгүй үзүүлсэн байна.



Энэ үзүүлэлтээс дүгнэхэд холбогдох хууль тогтоомжийн сурталчилгаа иргэдэд хүрч байгаа нь харагдаж байна.

ГУРАВ. ЭД ХӨРӨНГИЙН ЭРХИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЧИГЛЭЛЭЭР:

Тайлангийн хугацаанд иргэд, аж ахуйн нэгжээс газар болон газраас бусад үл хөдлөх эд хөрөнгийн нийт 15284-н мэдүүлэг хүлээн авч, 14510-н бүртгэл хөтлөн үйлчилгээний хураамж 196.382.906 төгрөгийг улсын төсөвт, үл хөдлөх эд хөрөнгө худалдсанаас оруулсан татварын орлого 891.473.529 төгрөг, тэмдэгтийн хураамж 5.356.202 төгрөг, нийт улс, орон нутгийн төсвийн дансанд 1.093.662.637 төгрөгийг тус тус төвлөрүүлэн ажиллалаа.

Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн чиглэлээр бүртгэсэн бүртгэлийн үйлчилгээний тоог төрлөөр нь харуулбал:

Эд хөрөнгө өмчлөх эрхийг анх удаа бүртгэж баталгаажуулах бүртгэл-3555

- Газар өмчлөх эрхийг анх удаа бүртгэж баталгаажуулах бүртгэл
 - Төрөөс үнэ төлбөргүй хувьчилсан газрын бүртгэл-384
 - Гэрээ хэлцлийн үндсэн дээр салгаж бүртгэсэн шинэ бүртгэл-41
- Газар эзэмших, ашиглах эрхийн анхны бүртгэл-2428
- Газраас бусад ҮХЭХ-ийг анхны удаа бүртгэж баталгаажуулах бүртгэл –743
 - Төрөөс хувьчилсан орон сууц-111
 - Газраас бусад үл хөдлөх эд хөрөнгө-304
 - Шинээр баригдсан орон сууц-221
 - Гэрээ хэлцлээр бүртгэл салсанаар шинэ бүртгэл-107

Гэрээний эрхийн бүртгэл-12240

- Худалдах, худалдан авах гэрээ-1712

- Бэлэглэлийн гэрээ –278
- Арилжааны гэрээ-37
- Өв залгамжлал, гэрээслэлээр өмчлөгч өөрчлөгдөх –261
- Барьцааны гэрээ, өөрчлөлт, дуусгавар болох бүртгэл –9632
- Хамтран өмчлөгч өөрчлөгдөх гэрээ-301
- Бусад гэрээ бүртгэх, дуусгавар болох-19

Гэрээ хэлцлээс бусад эрхийн бүртгэл –687

- Урьдчилсан тэмдэглэгээ бүртгэх, цуцлах –47
- Үрэгдүүлсэн, гэмтээсэн гэрчилгээ дахин авах бүртгэл-72
- Лавлагаа, хуулбар-530
- Хувийн хэрэг хаах-38

Бүртгэлд өөрчлөлт залруулга хийх-494

- Эд хөрөнгийн хэмжээ, гүйцэтгэл өөрчлөх-261
- Эд хөрөнгийн хаяг, зориулалт өөрчлөх-96
- Өмчлөгчийн овог нэр, регистр өөрчлөх-21
- Газрын нэгж талбарын дугаар өөрчлөх-116

Төрийн болон хууль хяналтын байгууллагаас ирүүлсэн 537-н албан бичигт хуулийн хугацаанд нь хариуг өгч, иргэн, хуулийн этгээдээс ирүүлсэн 20-н өргөдөл гомдлыг хянан холбогдох хариуг хугацаанд нь өгч ажиллалаа.

Анхны бүртгэлийн тоог сүүлийн 3 жилээр харьцуулвал:




Энэ графикаас харвал Төрөөс хувьчилсан орон сууцны тоо хэмжээ эрс эхэссэн нь энэ онд ОХУ-ын өмчлөлд байсан Дархан сум 4-р баг 22 дугаар хороололын 3,4 дүгээр байрыг МУ

ын талд шилжүүлэн өгч аймгийн Орон сууц хувьчлалын товчооноос өмнө нь эзэмшиж байсан иргэдэд хувьчилж өгсөнтэй холбоотой юм.

Шинээр баригдсан орон сууцны бүртгэл бага байгаа нь Монгол Улсад COVID-19 халдварт өвчин гарснаас шалтгаалан хөл хорио тогтоон хил, гааль хаагдан импортын бараа бүтээгдэхүүн орж ирэх нь багасч барилга, байгууламж барих бүтээн байгуулалт удааширсантай холбоотой юм.

Гэрээний эрхийн бүртгэлийг сүүлийн 3 жилийн байдлаар харуулбал:



Дархан Уул аймагт 2020 онд банкнаас олгож буй ипотекийн 8%-ийн зээл багассан боловч Банк бус байгууллагууд /Транскапитал, Газар капитал партнерс, Бид финанс/-ын зээл эрс нэмэгдсэн байна.

-Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хуулийн 28.2, 28.3 дахь зүйл заалтыг үндэслэн 2018 оны 11 дүгээр сараас тус тасаг улсын бүртгэлийн ерөнхий хуулийн 9.11-т заасны дагуу дундын мэдээллийн сан дахь мэдээлэлийг нягтлан шалгаж газар эзэмших, ашиглах эрхийг улсын бүртгэлд бүртгэж эхэлсэн.

2020 оны жилийн эцсийн байдлаар архивт хадгалагдаж буй эзэмших, ашиглах газрын бүртгэлийн хувийн хэргийг сум бүрээр харуулбал:

Д/д	Сумын нэр	Ашиглах		Өссөн дүнгээр	Эзэмших		Өссөн дүнгээр
		2018,2019 он	2020 он		2018,2019 он	2020 он	
1	Дархан	22	25	47	1259	1138	2397
2	Орхон	1	1	2	126	227	353
3	Шарын гол	0	0	0	46	101	147
4	Хонгор	1	4	5	601	962	1563
Нийт		24	30	54	2032	2428	4460

Тайлангийн хугацаанд эзэмших-2428, ашиглах-30 нийт 2458-н бүртгэлийн дугаарыг дундын мэдээллийн сангаас олгож нотлох баримтыг архивын нэгж үүсгэн архивт хүлээлгэн өгснөөс 359-н газрын гэрээ, гэрчилгээний хуулбарыг нөхөн авч, газрын даамал нь илгээгээгүй 419-н гэрээ, гэрчилгээг бүртгэсэн улсын бүртгэгчийн нэр болон сумаар ангилан аймгийн ГХБХБГ-т жагсаалт гарган хүргүүлсэн.

Газар эзэмших, ашиглах эрхээ бүртгүүлсэн иргэн, хуулийн этгээдийн 2458-н “Э” дугаартай бүртгэлийг EPRS-1 программд өмнө нь “Г” дугаартайгаар бүртгэдсэн эсэхийг шалгаж 14-н бүртгэлийн мэдээллийг ЭХЭУБГ-аас ирүүлсэн загварын дагуу үйлдэн ЭХЭБГ-ийн edkhourunqu@burtgel.gov.mn хаягаар хугацаанд нь хүргүүлж ажиллалаа.

УБЕГ-ын Захиргаа эрх зүйн хэлтсээс Эд хөрөнгийн бүртгэлийн чиглэлээр хууль хяналтын байгууллагаар шийдвэрлэгдэж байгаа хэрэг маргааны судалгааг 2017-2019 оны байдлаар гаргаж хугацаанд нь гаргаж хүргүүлсэн бөгөөд тайлангийн хугацаанд Иргэний хэргийн анхан шатны шүүхэд О.Ууганбаярын нэхэмжлэлтэй “Өвлөх эрхийн гэрчилгээ хүчингүй болгуулах”, Н.Манлайбаатарын нэхэмжлэлтэй “Бүртгэл хүчингүйд тооцуулах”, нийт 2 хэрэг маргаанд Дархан-Уул аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхэд хамтран хариуцагчаар Улсын бүртгэлийн хэлтсийг төлөөлж итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр томилогдон оролцож 1 хэрэг маргаан хэрэгсэхгүй болж, 1 хэрэг маргаан буцаж, 11 дүгээр сард дахин нэхэмжлэгч хүсэлт гаргасны дагуу хамтран хариуцагчаар Улсын бүртгэлийн хэлтсийг төлөөлөн оролцож байна.

Тайлангийн хугацаанд иргэн, хуулийн этгээдээс өмчлөлийн маргаантай холбоотой болон Төрийн байгууллага, Хууль хяналтын эрх бүхий байгууллагаас нийт 557-н албан тоот ирснээс эд хөрөнгийн эрх хязгаарласан тусгай тэмдэглэл бүртгүүлэхээр-81, тусгай тэмдэглэл цуцлуулахаар-55, Эд хөрөнгийн бүртгэлтэй холбоотой судалгаа авахаар-8, өмчлөлийн маргааний талаар өргөдөл гомдол-20, лавлагаа, хуулбар авахаар-393 албан тоот ирүүлснийг хуулийн хугацаанд бүртгэн баталгаажуулж хариуг хүргүүлэн 5035-н хуудас хуулбар олгож ажилласан.


ДӨРӨВ. ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЧИГЛЭЛЭЭР

2020 îîÛ жилийн эцсийн áàéäëààð хóóëëéí ÿðäÿÿäëéí улсын á¿ððäÿëÿÿð шинэ, нэмэлт өөрчлөлт, оноосон нэрийн баталгаажуулалт, татан буугдсан, дахин гэрчилгээ, салбар төлөөлөгчийн газрын бүртгэл, шилжсэн, хуулийн этгээдийн эцсийн өмчлөгчийн бүртгэлээр нийт 1148-н материалыг хүлээн авч бүртгэл óëñîíí á¿ððäÿëëéí òÿíäÿðèéí ðóðààìæààð 22016000 ÿÿíääí ò°äð°äëéä óëñîíí ò°ñ°àð, óíñííí íÿð, ðóóéààðòíí ¿éë+èèäÿÿíéé ðóðààìæ 139500 ò°äð°äííÿг тус тус холбогдох дансанд ò°äë°ð¿¿ÿí ажиллалаа. Үүнд:

- 1.Хуулийн этгээд шинээр үүсэн байгуулагдсаны бүртгэл-207
- 2.Хуулийн этгээдийн мэдээлэлд орсон өөрчлөлтийн бүртгэл -641
- 3.Хуулийн этгээдийн үйл ажиллагаа дуусгавар болсны бүртгэл-32
- 4.Хуулийн этгээдийн салбар, төлөөлөгчийн газрын бүртгэл -10
- 5.Хуулийн этгээдийн тамга, тэмдгийн хяналтын дугаарын бүртгэл-258

Дээрхи бүртгэлүүдийг 2020 оны үйл ажиллагааны тайлан "LES" болон ERS үйл ажиллагааны тайлан дахь архивт хувийн хэргийг хүлээлгэн өгч өгчөөрсөн.

Тайлангийн хугацаанд хөтөлсөн бүртгэлийн тоог сүүлийн 3 жилийн байдлаар харьцуулбал:



Дээрх графикаас үзэхэд 2020 оны бүртгэлийн тоо өссөн шалтгаан нь хуулийн этгээдийн эцсийн өмчлөгчийн бүртгэл тайлангийн хугацаанд хийгдэж байгаатай холбоотой байна.

Холбогдох хууль тогтоомж, дүрэм журмыг бүртгэлийн үйл ажиллагаандаа мөрдлөгө болгон ажиллаж тайлангийн хугацаанд татан буугдсан болон ашиглалтын шаардлага хангахгүй шалтгаанаар 74-н тамга тэмдэг хураан авч хүсэлт гаргасан иргэн, хуулийн этгээдэд 99-н лавлагаа, 112 хуудас нотлох баримтыг хуулбарлан олгосон. Мөн хуулийн этгээдийн нэрийн баталгаажуулалт 236, 96-н гэрчилгээ дахин олгож хүсэлт гаргасан 12 хуулийн этгээдийн хувийн хэргийг шилжүүлсэн.

Татварын багц хууль шинэчлэн батлагдаж "Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль"-д нэмэлт өөрчлөлт орсонтой холбоотойгоор 2020 оны 01 сарын 01-ний өдрөөс эхлэн

тайлангийн хугацаанд нийт 890-н хуулийн этгээдийн эцсийн өмчлөгчийн мэдээллийг мэдээллийн санд бүртгэсэн.

ТАВ. БҮРТГЭЛИЙН ХЯНАЛТЫН ЧИГЛЭЛЭЭР

Улсын бүртгэлийн ерөнхий хууль, Иргэний улсын бүртгэлийн тухай, Эд хөрөнгө эрхийн бүртгэлийн тухай, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль болон бусад дүрэм журамын хэрэгжилтэнд хяналт тавихдаа Төрийн хяналт шалгалтын тухай хууль, Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2019 оны А/289 дугаар тушаалаар батлагдсан “Улсын бүртгэлийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх журам”-ыг баримтлан чиг үүргийн дагуу дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ. Үүнд:

Нэг. Иргэний улсын бүртгэлийн чиглэлээр:

Иргэний бүртгэлийн чиглэлээр нийт 70-н өргөдөл гомдлын хүлээн авч Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулинд заасан хугацаанд улсын бүртгэлийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх журмын 22 дугаар зүйлийн 22.1-ийг баримтлан улсын байцаагчийн 65 дүгнэлтээр иргэний улсын бүртгэлтэй холбоотой тодорхой нөхцөл байдлуудыг тогтоон иргэдээс ирүүлсэн өргөдөл гомдлыг шийдвэрлэж ажиллаа. Үүнд :

- Регистрийн дугаар өөрчилж дахин олгох-4
- Бүртгэл хөтлөх тухай-5
- Бүртгэлд засвар, өөрчлөлт оруулах тухай-40
- Бүртгэл хүчингүй болгох тухай-7
- Зөрчил арилгах-4
- Регистрийн дугаар сэргээсэн-4
- Бүртгэл түдгэлзүүлсэн-1

Хаяж үрэгдүүлсэн, хүчинтэй байдлыг алдагдуулсан, дүр төрхийн өөрчлөлт орсон, овог нэр өөрчлөгдсөн, хаяг өөрчлөгдсөн үндэслэлээр 1140-н иргэний цахим үнэмлэхийг иргэний улсын бүртгэлийн мэдээллийн санд хүчингүй болгосон.

Монгол Улсын 16 нас хүрсэн иргэн анх удаа иргэний үнэмлэх авах, Иргэний улсын бүртгэлийн 16 дугаар зүйлийн 16.5, 16.6-г тус тус зөрчиж тогтоосон хугацаанд иргэний үнэмлэхээ солиулах гэсэн үүргээ биелүүлээгүй, Монгол Улсын иргэний үнэмлэхийн дүрмийн 2.7.1-д заасан иргэний үнэмлэхийг цэвэр гамтай эзэмших, хадгалах үүргээ биелүүлээгүй зөрчлөө өөрийн биеэр мэдээлэн ирсэн 1277-н иргэний гомдол мэдээллийг хүлээн авч Зөрчлийн тухай хууль болон Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн дагуу хялбаршуулсан журмаар шалган шийдвэрлэж 29550000 / хорин есөн сая таван зуун тавин мянган / төгрөгийн

торгуулийн шийтгэл оногдуулж Улсын бүртгэлийн хэлтсийн 5046309349 дугаарын дансанд төвлөрүүлсэн байна.

Дархан-Уул аймгийн Прокурын газраас 2020 оны 1 дүгээр улирлын хялбаршуулсан журмаар шалган шийдвэрлэсэн хэргүүдийг хууль тогтоомжийн дагуу шалгаж шийдвэрлэсэн эсэхэд хяналт шалгалт хийж шалгалтын дүнг танилцуулж 2020 оны 05 сарын 05-ны өдрийн 3-02 дугаарын албан шаардлага хүргүүлснийг хүлээн авч шаардлагад дурдагдсан зөрчлүүдийг арилган хариуг хүргүүлэн ажилласан болно.

Тайлангийн хугацаанд иргэний улсын бүртгэлийн чиглэлээр 2998-н бүртгэлд байнгын болон түүвэрчилсэн хяналт шалгалт хийсэн болно.

Хоёр. Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн талаар:

Хэлтсийн даргын баталсан 2020 оны 01 дүгээр сарын 02-ны өдрийн удирдамжийн дагуу эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн үйл ажиллагаанд төлөвлөгөөт шалгалтыг хийсэн. Шалгалтаар эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэгч нарын 2019 оны 1 дүгээр сарын 01-нээс 2019 оны 06 сарын 31-ний өдрийг дуустал хугацаанд бүртгэсэн нийт 10222-н бүртгэлийг архивын хувийн хэрэг дэх цаасан нотлох баримт болон эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн мэдээллийн сан дахь мэдээлэлтэй тулган шалгахад дараах зөрчлүүд илэрсэн. Үүнд:

1. Улсын бүртгэлд бүртгэгдсэн газар эзэмших, ашиглах эрхийн улсын бүртгэлийн хувийн хэргийг бүртгэл хийснээс хойш ажлын 1 хоногийн дотор архивт хүлээлгэн өгөөгүй зөрчил-713
2. Өмнө бүртгэгдсэн хүчинтэй эрхийн дахин улсын бүртгэл бүртгэсэн зөрчил-1
3. Нотлох баримт дутуу авч бүртгэл хөтөлсөн зөрчил-1
4. Нэгж талбарын дугаар болон нотлох баримтууд нь зөрүүтэй байхад бүртгэл хөтөлсөн зөрчил-1

Шалгалтаар илэрсэн зөрчлүүдийг арилгуулах зорилгоор 2020 оны 06 сарын 05-ны өдрийн Хяналтын улсын байцаагчийн албан шаардлага хүргүүлэн ажиллалаа.

Тайлангийн хугацаанд 10549-н бүртгэлд байнгын болон түүвэрчилсэн хяналт шалгалт хийснээс илэрсэн зөрчилгүй болно.

Эд хөрөнгийн бүртгэлийн мэдээллийн санд мэдээлэл тусгагдаагүй болон зөрүүтэй тусгагдсаныг залруулах зорилгоор эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэгч нараас гаргасан 75, хуулийн этгээдийн 2, иргэний 11 нийт 88 хүсэлтийг хүлээн авч хяналтын улсын байцаагчийн 107 дүгнэлт үйлдэж улсын бүртгэгч нарт хүлээлгэн өгсөн.

Гурав. Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн чиглэлээр:

Хуулийн этгээдийн 183-н бүртгэлд байнгын болон түүвэрчилсэн хяналт тавьж ажиллалаа. Үүнээс илэрсэн зөрчилгүй.

Хуулийн этгээдийн тамга тэмдэгээ гээгдүүлсэн зөрчлөө илчлэн мэдээлсэн 1 хуулийн этгээдийн гомдлыг хүлээн авч Зөрчлийн тухай хуулийн 1.5 дугаар зүйлийн 1.2-д заасан буюу хөөн хэлэлцэх хугацаа дууссан гэх үндэслэлээр гомдол мэдээллийг хүлээн авахаас татгалзан шийдвэрлэсэн болно.

Хуулийн этгээдийн бүртгэлтэй холбоотой хяналтын улсын байцаагчийн 1 дүгнэлт үйлдсэн байна.


Дархан-Уул аймгийн Цагдаагийн газраас харьяаллын дагуу шилжин ирсэн тамга тэмдэг хадгалах журам зөрчсөн гэх зөрчлийг хүлээн 2018000289 дугаарын зөрчлийн хэрэг үүсгэн шалгаж хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн.

Хяналт шалгалтын төлөвлөгөөний дагуу хуулийн этгээдийн 2019 оны бүртгэлийн үйл ажиллагаанд төлөвлөгөөт шалгалтын үйл ажиллагааг гүйцэтгэж байна.


ЗУРГАА. УЛСЫН БҮРТГЭЛИЙН АРХИВЫН ЧИГЛЭЛЭЭР:

1.Иргэний улсын бүртгэлийн архив:

Иргэний бүртгэлийн чиглэлээр мэдээлэл удирдах систем болон архивын цаасан эх нотлох баримтыг үндэслэн 10335 иргэнд, эрх бүхий байгууллагад 1929 лавлагаа олгож, өөр аймаг, нийслэлээс шилжин ирсэн 949 иргэний хувийн хэргийг хугацаанд нь шилжин ирсэн аймаг, нийслэлээс нэхэмжилж ажилласан. Лавлагаа олголтыг сараар харуулвал:



Тайлангийн хугацаанд иргэний бүртгэлийн чиглэлээр олгосон лавлагааг өнгөрсөн онуудын мөн үетэй харьцуулвал:



Иргэний баримтын архивын хадгаламжийн нэгж болох иргэний хувийн хэргийн тоон мэдээг улирал, жилээр тогтмол гарган хэвшсэн ба тус архивт 144436-н хадгаламжийн нэгж /хувийн хэрэг/ хадгалагдаж байна.

Төрөлтийн бүртгэл, нас барсны бүртгэл, ИШБ-д хамрагдсан, хамрагдаагүй, иргэний үнэмлэх аваагүй, харьяатаас гарсан иргэдийн хувийн хэргийг галиглан тус тусад нь сан үүсгэсэн.

Мөн тайлангийн хугацаанд улсын бүртгэгч нараас хүлээлгэн өгсөн бүртгэлийн ИУБ маягт болон өөр аймаг, нийслэлээс ирүүлсэн иргэний хувийн хэргийг тухай бүр нь холбогдох сангуудад байршуулан ажилласан.

Улсын бүртгэлийн ерөнхий газрын дарга, Архивын ерөнхий газрын даргын хамтарсан 2020 оны 11 дүгээр сарын 02 ны өдрийн А/14371-А/110 дугаар “Хадгалах хугацааны жагсаалт шинэчлэн батлах тухай” тушаалаар баталсан “Улсын бүртгэлийн салбарын үйл ажиллагааны явцад бий болсон баримт бичгийн хадгалах хугацааны жагсаалтын дагуу иргэний хувийн хадгалалт хамгаалалтад тогтмол хяналт тавьж ажиллан архивын өрөөний чийг, дулааныг өдөр тутам хэмжин бүртгэлийн дэвтрийг хөтлөж, цэвэрлэгээ үйлчилгээг хуваарийн дагуу хийлгэн ажилласан.




2. Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн архив:

Тайлангийн хугацаанд эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн архивт нийт 44377 хувийн хэрэг хадгалагдаж байна. Үүнд:

Газар өмчлөх эрхийн бүртгэл-13819,

Газраас бусад үл хөдлөх эд хөрөнгийн-26044

Газар эзэмших, ашиглах эрхийн бүртгэлийн-4514



2020 онд шинээр Газар өмчлөх эрхийн бүртгэл-384, Газраас бусад үл хөдлөх эд хөрөнгийн-743 Газар эзэмших, ашиглах эрхийн бүртгэлийн-2458 анхны бүртгэлийг улсын бүртгэгч нараас хүлээн авч архивын нэгж үүсгэн байршуулсан.

Улсын бүртгэгч нарын өдөр тутам бүртгэсэн бүртгэлийн материалыг “Архивт хүлээлгэн өгсөн хувийн хэрэг, эрх нотлох баримтын бүртгэл”-ийн дэвтрээр хүлээн авч нягтлан шалгаж, нотлох баримтыг хуудас, дарааллын дагуу бүрэн эсэхийг нягтлан шалгаж улсын бүртгэгч нараас мэдүүлгээр хүлээн авч бүртгэсэн газар өмчлөх эрхийн 3868, газраас бусад үл хөдлөх эд хөрөнгийн 9515 бүртгэл, хууль хяналтын байгууллагаас албан тоотоор ирүүлсэн эрх сэргээсэн, түдгэлзүүлсэн болон лавлагаа олгосон 1150 тус тус баяжилтийн бүртгэлийг улсын бүртгэгч нараас хүлээн авч бүртгэлийн журнал хөтлөн хувийн хэрэгт байршуулсан.

Захиалгын хуудсаар улсын бүртгэгч нарт 4400, УБЕГ-ын Хяналт шалгалтын багт 750, хэлтсийн хяналтын улсын байцаагч Б.Хишгээ, Б.Цогзолмаа нарт 371, шүүгчийн захирамжийн дагуу 2 нийт 5523 хувийн хэргийг архиваас гарган өгч тэмдэглэл хөтлөн буцаан байршуулсан.

Архивын ерөнхий газрын даргын 2010.01.25ны өдрийн №А/13-т “Цаасан баримтыг сэргээн засварлах ажлын заавар батлах тухай” тушаалын 4.3.5-д заасан дагуу нотлох баримтын цаасны зах ирмэг урагдаж салбарсан, тасарч алга болсон, үдэлт нь сэтэрсэн, зэрэг

2020 оны үйл ажиллагааны тайлан

гэмтэлтэй хэсгийг нөхөн сэлбэх ажлыг тогтмол хийж нийт 67-н хувийн хэргийг засварлаж, нягтруулсан шүүгээнд заагч тавиурыг сольж шинэчиллээ




3. Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн архив:

Хуулийн этгээдийн архивт шинэчилсэн бүртгэлд хамрагдсан - 4201, Улаанбаатар хотоос шилжин ирсэн шинэчилсэн бүртгэлд хамрагдсан – 57, УБ хотоос шилжин ирсэн шинэчилсэн бүртгэлд хамрагдаагүй -183, Дархан-Уул аймагт шинэчилсэн бүртгэлд хамрагдаагүй 52, нийт 4493 хувийн хэрэг хадгалагдаж байна. Тайлангийн хугацаанд 207-н анхны бүртгэлийн хувийн хэрэг нэмэгдсэн байна.

ДОЛОО. БАЙГУУЛЛАГЫН АРХИВЫН ЧИГЛЭЛЭЭР:

Хэлтсийн Баримт бичиг нягтлан шалгах комиссын бүрэлдэхүүн, байгууллагын архивын дүрэм, ББНШК-ын дүрмийг хэлтсийн даргын 2020 оны 04 дүгээр сарын 23 ны өдрийн А/08 дүгээр тушаалаар тус тус шинэчлэн батлуулсан.

Байгууллагын ББНШК нь Архивын тухай хууль, байгууллагын архивын ажлын үндсэн заавар болон бусад холбогдох эрх зүйн актын дагуу 2020 оны 1 дүгээр улиралд хэлтсийн нийт албан хаагчдаас 2019 онд хөтлөгдсөн 276 хадгаламжийн нэгж, 62 бүртгэлийн дэвтэр хүлээн авсан.



Тайлангийн хугацаанд нийт хадгалах хугацаа нь дууссан 218-н хадгаламжийн нэгж, 45512 хуудас баримтыг устгасан.

НАЙМ. АЛБАН ХЭРЭГ ХӨТЛӨЛТИЙН ЧИГЛЭЛЭЭР

Монгол улсын “Архивын тухай”, Архивын Ерөнхий газрын даргын 2009 оны 68 дугаар тушаалаар батлагдсан “Төрийн албан хэрэг хөтлөлтийн үндсэн заавар”, Стандартчилал Хэмжил зүйн Үндэсний зөвлөлийн 2011 оны 02 дугаар тогтоолоор баталсан “Баримт бичгийн стандарт”-ын дагуу хэлтсийн албан хэрэг хөтлөлтийн өдөр тутмын үйл ажиллагаа, баримт бичгийг “Able Cloud” системийн “Албан бичиг” программыг ашиглан албан хэргийг хөтөлж байна.

“Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай” хууль, дүрэм журамд заасны дагуу 193-н өргөдөл бичгээр хүлээн авсан бөгөөд хуулийн хугацаанд нь 147-н өргөдлийг хянан шийдвэрлэсэн бөгөөд 46-н өргөдөл шийдвэрлэлтийн хугацаандаа хянан шалгагдаж байна.

Жилийн эцсийн байдлаар нийт 147-н өргөдөл, гомдол, санал, хүсэлтийг хуулийн хугацаанд шийдвэрлэсэн бөгөөд шийдвэрлэлтийн байдал 76.1 хувьтай байна. Хүлээн авсан өргөдлийн тоог 2018, 2019 онуудын тоон үзүүлэлттэй харьцуулбал:



Энэ харьцуулалтаас дүгнэхэд жилээс жилд иргэдээс бүртгэлийн байгууллагад гаргах өргөдлийн тоо буурсан эерэг үзүүлэлттэй харагдаж байна.

УБЕГ-ын Тамгын газарт улирлын өргөдөл, гомдлын мэдээг 2 удаа 1, 2 дугаар улиралд батлагдсан загварын дагуу хугацаанд нь гаргаж хүргүүлсэн.


Тайлангийн хугацаанд дээд байгууллага, төрийн болон төрийн бус байгууллага, эрх бүхий байгууллагаас ирсэн 1384, явуулсан 1580 нийт албан бичиг 2964 байна. 1384 ирсэн бичгийн ангилал дараах байдалтай байна.

1. Улсын бүртгэлийн ерөнхий газраас-92
2. Дархан-Уул аймгийн Цагдаагийн газраас- 334
3. Дархан-Уул аймаг дахь Шийдвэр гүйцэтгэх газар 445, 435-р хорих анги- 273
4. Шүүхийн байгууллагаас-118
5. Бусад байгууллагаас-567

2020 оны үйл ажиллагааны тайлан

2020 оны байдлаар тус хэлтсээс явуулсан албан бичиг 1580, хэлтсийн даргын А -17, Б-17 нийт 34 тушаал батлагдан хэрэгжиж байна.

Албан хэрэг хөтлөлтийн стандартын дагуу ирсэн, явуулсан албан бичиг өргөдөл, гомдлыг тухай бүрд цахим болон цаасан хэлбэрээр бүртгэн Able Cloud” программдаа скайнердан оруулж хяналтын карт хөтлөн удирдлагад танилцуулж ажилласан. Ирсэн, явуулсан бичгийн тоог өмнөх онуудын тоон дүнтэй харьцуулбал:



ЕС. ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЛААР

Тайлангийн хугацаанд тус хэлтэс урсгал санхүүжилтээр 397.725.700 мянган төгрөгийн санхүүжилт авч гүйцэтгэл дараах байдалтай байна. 308.524.100 мянган төгрөгийг цалинд, 41.650.700 мянган төгрөгийг НДШ-ийн зардалд, 20.825.400 мянган төгрөгийг байрны түрээсийн зардалд, 34.020.000 мянган төгрөгийг бичиг хэргийн зардалд, 5.003.300 мянган төгрөгийг тээвэр шатахууны зардалд, 1.400.800 мянган төгрөгийг шуудан холбоо, бага үнэтэй түргэн элэгдэх зүйлсийн зардалд 1.400.800 мянган төгрөгийг, дотоод албан томилолтын зардалд 198,000 мянган төгрөгийг зарцуулж байгууллагын төсвийн гүйцэтгэлийн тайлан 12 удаа гаргаж УБЕГ-ын Санхүү төлөвлөлтийн газар болон аймгийн ЗДТГ-ын Санхүү төрийн сангийн хэлтэст сар бүр тогтмол хугацаанд нь гарган өгч, байгууллагын өдөр тутмын хэвийн үйл ажиллагааг хангаж ажиллалаа.

2020 оны 4-р улирлын санхүүгийн тайланг хуулийн хугацаанд гарган УБЕГ-ын Санхүү төлөвлөлтийн газарт хүргүүлэхээр ажиллаж байна.

Байгууллагын санхүүгийн ил тод байдлыг хангах үүднээс “Санхүү, хүний нөөцийн ил тод байдлын самбар”-ыг шинэчлэн батлагдсан төсөв болон түүний гүйцэтгэл, байгууллагын бүтэц орон тоо, аудитын дүгнэлт, төсвийн хэмнэлт, хэтрэлт болон бусад холбогдох мэдээллийг байршуулан ажиллаж байна.

2020 оны үйл ажиллагааны тайлан

- Шилэн дансны веб сайтад байгууллагын холбогдох мэдээллийг цаг хугацаанд нь байршуулж ирлээ. Тайлангийн хугацаанд шилэн дансны мэдээллийг бүрэн байршуулсан бөгөөд нийт 151-н мэдээлэл байршуулахаас мэдээллийг 100 хувь хугацаанд нь байршуулан ажилласан.

- 2020.05.06-ны өдрийн Засгийн газрын 168 дугаар тогтоолын дагуу тэвчиж болох зардлыг бүх талаар хэмнэж ажиллалаа. Үнэт цаас зарцуулалтын тооцоог улсын бүртгэгч бүрээр хийж эхний 11 сарын тайланг УБЕГазрын Санхүү төлөвлөлтийн газарт хүргүүлж тулгалт хийхэд гарсан алдаа зөрчил илрээгүй.

- Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газраас 2020 оны 02 дугаар сарын 17-ны өдрийн 77 тоот албан бичгээр 2019 оны санхүүгийн үйл ажиллагааны тайланд хийсэн шалгалтаар зөрчилгүй дүгнэлттэй шалгагдсан тухай аудитын баталгаажуулсан тайланг зөвлөмжийн хамт ирүүлсэн. Ирүүлсэн зөвлөмжийн хэрэгжилтийг ханган ажилласан.

- Тайлант оны 4 дүгээр улирлын бараа материалын тайланг гарган ажиллаж, батлагдсан төсвийн хүрээнд хэвийн үйл ажиллагааг тасралтгүй, өр, авлага үүсгэхгүйгээр зохион байгуулан ажиллаж байна.

-“Төрийн албаны цалингийн нэгдсэн систем” –ийг улс орон даяар үе шаттайгаар нэвтрүүлэх төлөвлөгөөний дагуу Дархан-Уул аймаг сонгогдсон тул Хүний нөөцийн удирдлагын системтэй уялдаж нэгдсэн нэг системд холбогдож байгууллагын албан хаагчдын цалинг тухайн системээр бодож олгож байна.

- Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын “Монгол Улсын Их Хурлын ээлжит сонгууль зохион байгуулах зардлын төсөв батлах тухай” 2020 оны 05 дугаар сарын 06-ны өдрийн А/595 дугаар тушаалаар 52.575.800 төгрөгийн төсөв батлагдсан. Төсвийг батлагдсан зардлын дагуу зарцуулан тус аймаг дахь Төрийн аудитын газрын 2020 оны 07 дугаар сарын 10 ны өдрийн 395 тоот албан бичгийн дагуу баримтыг хүргүүлж гүйцэтгэлийн аудит хийлгэсэн.

- Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын “Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ь сонгууль зохион байгуулах зардлын төсөв батлах тухай” 2020 оны 09 сарын 02-ны өдрийн А/1304 дүгээр тушаалаар 31.415.500 төгрөг батлагдсан. Тус зардлыг баталсан төсвийн дагуу гаргаж тус аймаг дахь Төрийн аудитын газрын 2020 оны 11 дүгээр сарын 10 ны өдрийн 520 тоот албан бичгийн дагуу баримтыг хүргүүлж гүйцэтгэлийн аудит хийлгэсэн.

- Шуудан холбооны батлагдсан төсөв нь хүрэлцэхгүйн улмаас 2020 оны жилийн эцсийн байдлаар Монгол шуудан ХХК-нд шуудан холбооны 1.854.435 төгрөгийн өр үүсэн байна.

- Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2020 оны 03 дугаар сарын 20 ны өдрийн “Төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэв олгох тухай” Б/136 дугаар тушаалын хэрэгжилтийг 2020 оны 07 дугаар сарын 01 ний өдрөөс ханган ажиллаж байгаа бөгөөд

2020 оны үйл ажиллагааны тайлан

цалингийн сан хүрэлцэхгүйн улмаас УБЕГ-ын Санхүү төлөвлөлтийн газарт мэдэгдсэнээр 6.000.000 төгрөг үндсэн цалингийн санд нэмж олгуулан ажиллалаа.


- Коронавирус /COVID-19/-ын халдвар, тархалтаас урьдчилан сэргийлэх үүднээс биеийн халуун хэмжигч багаж 1 ширхэгийг 150.000 төгрөгөөр, зориулалтын хамгаалалтын хувцас 7 ширхэг, халад 6 ширхэг, малгай 30 ширхэгийг 258.000 төгрөгөөр, маск 2450 ширхэгийг 100-1000 төгрөгөөр, нэг хэрэглээний бээлий 700 ширхэгийг 50,000 төгрөгөөр, 5л спирт 6 ширхэгийг 80,000 төгрөгөөр, хана, шал, хаалганы ариутгах ариутгалын бодис 2 хайрцаг 158,000 төгрөгөөр, гар ариутгагч 140,000 төгрөгөөр худалдан авч нөөц үүсгэн албан хаагчдад тарааж, зохих журмын дагуу ариутгал цэвэрлэгээг хийж ажиллалаа.

АРАВ: МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИЙН ЧИГЛЭЛЭЭР

Хэлтсийн Da.burtgel.gov.mn сайтад тайлант хугацаанд нийт 49-н удаа мэдээлэл оруулж үйл ажиллагааг сурталчиж, ил тод байдлыг хангаж ажиллалаа.



Дархан-Уул аймаг Улсын бүртгэлийн хэлтэс Page хуудсанд хагас жилийн байдлаар 201 удаагийн мэдээлэл байршуулсан байна.



Хонгор сум, Шарын гол сум, Орхон сумдын ИУБ-31 Export-ийн 192.168.154.100 –д тухай бүр байршуулж байна.

450700_31_254_20191024_032833	19.10.28 11:42	Data Base File	2 162 KB
450700_31_255_20191106_035742	19.11.07 9:05	Data Base File	5 866 KB
450700_31_256_20191129_120510	19.12.02 8:22	Data Base File	5 490 KB
450700_31_257_20191216_023700	19.12.17 11:20	Data Base File	5 649 KB
450700_31_258_20191222_042115	19.12.26 14:15	Data Base File	3 042 KB
450700_31_259_20200107_113449	20.01.07 17:22	Data Base File	4 100 KB
450700_31_260_20200120_062446	20.01.28 8:35	Data Base File	2 321 KB
450700_31_261_20200204_023225	20.02.04 17:11	Data Base File	4 309 KB
451000_31_176_20190228_025034	19.03.01 7:28	Data Base File	22 768 KB

2020 оны үйл ажиллагааны тайлан

Иргэний, эд хөрөнгийн, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн 1-11 дүгээр сарын инфографик мэдээллийг хугацаанд нь гаргаж Da.burtgel.gov.mn сайт болон Page хуудсанд байршуулсан.



Иргэн, хуулийн этгээд, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн болон нэгдсэн архивын мэдээллийн сан, системүүд болон сүлжээ, техник тоног төхөөрөмжийн тасралтгүй хэвийн ажиллагааг ханган ажиллаж байна. Мөн эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тасгийн том сапон болон хуулийн этгээдийн улсын бүртгэгчийн 1660 принтерт засвар үйлчилгээ хийлгэж хэвийн ажиллагааг хангасан.

Албан хаагчдын ажилчдын цаг бүртгэлийг <https://www.intranet.gov.mn/> програмаас тухай бүрт сарын сүүлээр татан авч хэлтсийн дарга, нягтлан бодогч нарт танилцуулан ажилласан.

Улсын бүртгэлийн нэгж	Ажилчин нэр	Ажилын үйлчилгээ	Урьд	Одоо	Тусгал	Тусгал	Тусгал	Тусгал
000001	А.Батбаяр	Урьд	00	00	00	00	00	00
000002	Б.Батбаяр	Урьд	00	00	00	00	00	00
000003	В.Батбаяр	Урьд	00	00	00	00	00	00
000004	Г.Батбаяр	Урьд	00	00	00	00	00	00
000005	Д.Батбаяр	Урьд	00	00	00	00	00	00
000006	Е.Батбаяр	Урьд	00	00	00	00	00	00
000007	Ж.Батбаяр	Урьд	00	00	00	00	00	00
000008	З.Батбаяр	Урьд	00	00	00	00	00	00
000009	И.Батбаяр	Урьд	00	00	00	00	00	00
000010	Л.Батбаяр	Урьд	00	00	00	00	00	00
000011	М.Батбаяр	Урьд	00	00	00	00	00	00
000012	Н.Батбаяр	Урьд	00	00	00	00	00	00
000013	О.Батбаяр	Урьд	00	00	00	00	00	00
000014	П.Батбаяр	Урьд	00	00	00	00	00	00
000015	Р.Батбаяр	Урьд	00	00	00	00	00	00
000016	С.Батбаяр	Урьд	00	00	00	00	00	00
000017	Т.Батбаяр	Урьд	00	00	00	00	00	00
000018	У.Батбаяр	Урьд	00	00	00	00	00	00
000019	Ф.Батбаяр	Урьд	00	00	00	00	00	00
000020	Х.Батбаяр	Урьд	00	00	00	00	00	00
000021	Ц.Батбаяр	Урьд	00	00	00	00	00	00
000022	Ч.Батбаяр	Урьд	00	00	00	00	00	00
000023	Ш.Батбаяр	Урьд	00	00	00	00	00	00
000024	Ы.Батбаяр	Урьд	00	00	00	00	00	00
000025	Я.Батбаяр	Урьд	00	00	00	00	00	00

Хэлтсийн 1 давхарын үйлчилгээний заалны 3 ширхэг камер болон 2 давхарын 3 ширхэг камер, эд хөрөнгийн архивын архивын 1 ширхэг камер нийт 7-н ширхэг камерын хэвийн үйл ажиллагаанд хяналт тавьж ажилласан. Эхний хагас жилийн байдлаар тус камеруудтай холбоотой ямар нэгэн зөрчил гараагүй.


2020 оны 1 дүгээр улиралд тус аймгийн Дархан сумын Дархан Захад байрлах “Нийтийн үйлчилгээний нэгдсэн төв”-д улсын бүртгэлийн шилэн кабел оруулсантай холбоотойгоор бүртгэлийн үйлчилгээ үзүүлж буй 2 улсын бүртгэгчийн компьютерт сүлжээний холболт хийж

хэвийн ажиллагааг хангасан. УБЕГ-аас зохион байгуулсан 25-н удаагийн онлайн сургалтын бэлтгэл ажил, сүлжээ техникийн бэлэн байдлыг хангаж ажилласан.

АРВАН НЭГ. УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХУУЛЬ ТОГТООМЖ, ҮЙЛЧИЛГЭЭГ ОЛОН НИЙТЭД СУРТАЛЧЛАХ, БҮРТГЭЛИЙН ҮЙЛЧИЛГЭЭГ ЧИРЭГДЭЛГҮЙ ТҮРГЭН ШУУРХАЙ ХҮРГЭХ, ИРГЭДИЙН ЭРХ ЗҮЙН МЭДЛЭГИЙГ НЭМЭГДҮҮЛЭХ АЖЛЫГ ЗОХИОН БАЙГУУЛАХ АЖЛЫН ХҮРЭЭНД



Тайлангийн хугацаанд улсын бүртгэлийн хууль тогтоомж, үйлчилгээг олон нийтэд сурталчлах, бүртгэлийн үйлчилгээг чирэгдэлгүй түргэн шуурхай хүргэх, иргэдийн эрх зүйн мэдлэгийг нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулах ажлын хүрээнд дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн. Үүнд:

1. Дархан сумын Дархан зах дотор байрлах “Нийтийн үйлчилгээний нэгдсэн төв” болон хэлтсийн үйлчилгээний зааланд байрлах Led дэлгэцүүдээр болон хэлтсийн цахим хуудсуудаар бүртгэлийн үйлчилгээг түргэн шуурхай, чирэгдэлгүй хүргэх зорилгоор Улсын бүртгэлийн ерөнхий газраас үзүүлдэг 105 төрлийн үйлчилгээ, лавлагааны үйлчилгээний төлбөрийг “Цахим төлбөрийн баримтын систем” буюу [ebarimt аппликейшн ашиглан](#) гар утаснаасаа интернет банкаар төлөх үйлчилгээ болон иргэдэд зориулсан мэдээ мэдээллийг тогтмол байршуулан сурталчилан ажилласан. Үүний үр дүнд 2020 оны жилийн эцсийн байдлаар 449 иргэн цахим төлбөрийн баримтын систем буюу [ebarimt аппликейшн ашиглан](#) үйлчилгээний хураамжаа төлж бүртгэлийн үйлчилгээ авсан байна.



Burtgel.mn цахим хаягаар иргэний үнэмлэхээ үрэгдүүлсэн нийт 49-н иргэний хүсэлт ирүүлснийг баталгаажуулан иргэний үнэмлэх дахин олгосон.

2.Мөн Дархан зах дотор байрлах “Нийтийн үйлчилгээний нэгдсэн төв” болон хэлтсийн үйлчилгээний зааланд байрлах Led дэлгэцээр иргэдэд, аймгийн төрийн байгууллагуудын албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа Able програмын олон нийтийн цэсэнд, хэлтсийн вэб сайт болон пэйж хуудсанд улсын бүртгэлийн цахим хуудсанд байршуулсан сонгогчдийн нэрийн жагсаалт дахь өөрт холбогдох мэдээлэлтэй хэрхэн танилцах тухай мэдээллийг байршуулан төрийн байгууллага, албан хаагчдад тогтмол сурталчилж ажилласан.



3.Тайлангийн хугацаанд ШШГЕГ-ын харьяа хаалттай 435, нээлттэй 445 дугаар хорих ангиудад ял эдлэж буй нийт 25 хүмүүжигчийг бичиг баримтжууллаа.



4.Тайлангийн хугацаанд өөрийн биеэр ирж бүртгэлээ хийлгэх боломжгүй хөгжлийн бэрхшээлтэй 1 иргэнийг гэрээр нь очиж бүртгэлийн үйлчилгээг үзүүлсэн.



5.Хэлтсийн ажлын байранд байрлах “Төрийн үйлчилгээний нэгдсэн төв”, Дархан зах дотор байрлах “Нийтийн үйлчилгээний нэгдсэн төв” –ээр үйлчлүүлж буй иргэдэд иргэн, эд хөрөнгө, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн төрөл бүрээр гарын авлага, тараах материал бэлтгэж тараан, зөвлөгөө, мэдээллийг тогтмол өгч ажиллаж байна.



6. Дархан сумын улсын бүртгэгч нарын санаачлагаар 2020 оны 05 дугаар сарын 15 ны өдөр “Дэлхийн гэр бүлийн өдөр”-өөр тухайн өдөр гэрлэлтээ бүртгүүлсэн 2 гэр бүлд гэрчилгээг нь ёслол хүндэтгэлтэйгээр дурсгалын зүйлийн хамт гардуулсан.



7. Хэлтсийн da.burtgel.gov.mn сайт болон [/darkhan.burtgel/](http://darkhan.burtgel/) page хуудас, Дархан Улсын бүртгэлийн хэлтэс facebook хуудсаар холбогдох мэдээллүүдийг тогтмол давтамжтайгаар оруулж, аймгийн ЗДТГ-ын “Нээлттэй төр” шууд нэвтрүүлгээр 3, орон нутгийн DBS, RGB телевизүүдтэй 5 удаа хамтран ажиллаж иргэдэд бүртгэлийн үйлчилгээг авахдаа бүртгэлийн байгууллагад өөрийн биеэр ирэхгүйгээр цахимаар хэрхэн авах burtgel.mn хаягнаас хэрхэн лавлагаа авах болон цахим бүртгэлийн ач холбогдлын талаар мэдээлэл өгч ажилласан.



8. Улсын Онцгой комиссын 2020 оны 04 дүгээр сарын 11-ний өдрийн 9 дүгээр тогтоолоор батлагдсан “Амны хаалтаа зүүцгээе” аяны хүрээнд байгууллага дээр 2020 оны 03 дугаар сарын 02-оос 2020 оны 05 дугаар сарын 29-ний өдөр хүртэл хэлтсийн даргын баталсан хуваарийн дагуу хариуцлагатай жижүүрээр 1-2 цагаар ээлжлэн сууж ажиллан үйлчлүүлэгч иргэдийн гарыг ариутгаж, халуун хэмжигчээр биеийн халууныг хэмжиж вирусийн тархалтаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч ажилласан.



9. Мөн Улсын бүртгэлийн ерөнхий газрын Тамгын газраас ирүүлсэн дотоод албан бичгээр ирүүлсэн чиглэлийн дагуу Коронавируст халдвар /Ковид-18/-аас урьдчилан сэргийлэх “Амны хаалтаа зүүцгээе” аяны хүрээнд хэлтсийн албан хаагчид ажлын байранд дасгал хөдөлгөөнийг хийж, зурагт шторк хийн хэлтсийн da.burtgel.gov.mn сайт болон [/darkhan.burtgel.gov.mn](http://darkhan.burtgel.gov.mn) раје хуудас, Дархан Улсын бүртгэлийн хэлтэс facebook хуудсуудад байршуулан өрнүүлсэн аянд нэгдсэн.



10. Монгол Улсад бүртгэлийн байгууллага үүсэж хөгжсөний 80 жилийн ой, улсын бүртгэлийн ажилтны өдөр”ийг тохиолдуулан “НЭЭЛТТЭЙ ХААЛГАНЫ ӨДӨРЛӨГ”-ийг Дархан сумын 1, 2, 3, 15 дугаар багийн төвүүдэд 2020.11.01-2020.11.03, Хонгор сумын Салхит 3 дугаар баг, Шарын гол, Орхон сумдад 2020.11.04-2020.11.06 өдрүүдэд зохион байгуулан ажилласан.. Өдөрлөгөөр бүртгэлийн үйлчилгээг 372 иргэнд үзүүлж 280 гаруй иргэнд бүртгэлийн үйлчилгээг цахим хэлбэрээр хэрхэн авах тухай танилцуулахаас гадна хууль тогтоомжид заасан хугацаанд улсын бүртгэлд бүртгүүлээгүйгээс үүсэх зөрчил, үйлдсэн зөрчилд Зөрчлийн тухай хуулиар шийтгэл оногдуулах арга хэмжээ, зөрчил үйлдэхээс хэрхэн урьдчилан сэргийлэх талаар зөвлөгөө мэдээллийг хүргэж, 25 хуулийн этгээдийн эцсийн өмчлөгчийг бүртгэн, 70 гаруй хуулийн этгээдийн эрх бүхий албан тушаалтанд 2020 ондоо багтан эцсийн өмчлөгчөө бүртгүүлэх талаар мэдээлэл хүргэж ажилласан байна. Хуулийн этгээдийн эцсийн өмчлөгчийн мэдээллээ хуулийн хугацаанд бүртгүүлэх тухай мэдээлэл зөвлөмжийг өгч ажиллалаа.



АРВАН ХОЁР. ХҮНИЙ НӨӨЦИЙН ЧАДАВХИЙГ БЭХЖҮҮЛЭХ, МЭДЛЭГ ЧАДВАРЫГ ДЭЭШЛҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР

2020 оны жилийн эцсийн байдлаар хүний нөөцийн чадавхийг бэхжүүлэх, мэдлэг чадварыг дээшлүүлэх чиглэлээр дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн.

1. Иргэний улсын бүртгэлийн тасгийн хүүхэд асрах чөлөөтэй байгаа 1 улсын бүртгэгч, Шарын гол сумын улсын бүртгэгчийн орон тоо дутуу байсанд холбогдох саналыг хүргүүлэн УБЕГ-ын даргын 2020 оны Б/173, Б/182 тушаалаар улсын бүртгэгчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, улсын бүртгэгч нарыг томилуулан ажилласан.

2. Их засаг их сургуулийн Бямба, Ням гарагийн бакалаврын эчнээ ангид 3 албан хаагч, магистрийн ангид 2 албан хаагч элсэн суралцаж байна.

3. Тайлангийн хугацаанд Улсын бүртгэлийн ерөнхий газраас зохион байгуулсан 25 удаагийн онлайн сургалтад холбогдох албан хаагчдыг бүрэн хамруулсан.



4. Хэлтсийн 2020 оны сургалтын төлөвлөгөөний дагуу улсын бүртгэгч нарт бүртгэлийн хууль тогтоомжийг нэг мөр ойлгуулах хүрээнд 2 удаа, гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, тайлагнах сэдвээр 1 удаа, Татварын ерөнхий хуулийн шинэчилсэн найруулга сэдвээр 1 удаа,

2020 оны үйл ажиллагааны тайлан

нийт 4 удаагийн танхимын сургалтыг Эрүүл мэндийн яамнаас гаргасан зөвлөмжийн дагуу хэлтсийн албан хаагчдад 1-2 дугаар улиралд зохион байгуулсан.

5.Улсын бүртгэлийн ерөнхий газраас ирүүлсэн чиглэл, хөтөлбөрийн дагуу тус хэлтсийн итгэмжлэгдсэн ажилтнаар томилогдсон Улсын Их Хурлын сонгуулийн 19 дүгээр тойрогийн 39 хэсгийн хороонд ажиллах 67 итгэмжлэгдсэн ажилтанд хууль, эрх зүйн сургалтыг 2020 оны 05 дугаар сарын 20, 22-ны өдрүүдэд танхимаар зохион байгуулсан.



6.Улсын бүртгэлийн ерөнхий газраас ирүүлсэн чиглэл, хөтөлбөрийн дагуу сургалтын бэлтгэл ажлыг ханган тус хэлтсийн холбогдох албан хаагчид болон итгэмжлэгдсэн ажилтнаар томилогдсон Улсын Их Хурлын сонгуулийн 19 дүгээр тойрогийн 39-н хэсгийн хороонд ажиллах 67-н итгэмжлэгдсэн ажилтнуудын ирц бүртгэлийн программын сургалтыг 2020 оны 06 дугаар сарын 14, 15-ны өдрүүдэд УБЕГ-ын сургалтын багтай хамтран аймгийн Засаг даргын Тамгын газарт танхимаар зохион байгуулан ажилласан.

Сургалтын явцад зохион байгуулалт, цаг ашиглалтын асуудал болон техникийн саатал гаралгүй хөтөлбөрийн дагуу сургалт амжилттай явагдаж дууссан.



Компьютер, тоног төхөөрөмжийг аймгийн Тагнуулын хэлтэс, Цагдаагийн газрын ажилтны хяналт дор тараан өгч тоног төхөөрөмж хүлээлгэн өгсөн протоколыг 3 үйлдэн баталгаажуулсан.

Сонгогчдын нэрийн жагсаалт /СНЖ/-д сургалтын явцад 793 ширхэг өөрчлөлтийн лавлагааг тусгасан. Үүнд:

Шилжин явсан сонгогчийн 336 ш

- Шилжин ирсэн сонгогчийн 429 ш
- Иргэний улсын бүртгэлийн өөрчлөлтийн 28 ш /нас барсан-21, харьяатаас гарсан -1, бусад-6/

СНЖ-ийн цахим сангийн сонгогчийн хувийн мэдээллийн нягтлан шалгах программаас СНЖ-ийг хэвлэх, бүртгэл хөтлөх ажлыг зохион байгуулан сургалтын багийн ахлагч, хэлтсийн даргаар болон итгэмжлэгдсэн ажилтнуудаар СНЖ, холбогдох актуудыг баталгаажуулан аймгийн хэмжээнд нэгтгэх ажлыг хийж гүйцэтгэсэн.



СНЖ-ын программыг акт үйлдэн түгжих, битүүмжлэн лацдах ажлыг зохион байгуулан маягт, протоколыг үйлдэж компьютер, тоног төхөөрөмжүүдийг аймгийн Тагнуулын хэлтэс, Цагдаагийн газрын ажилтны хамгаалалтанд хүлээлгэж өгсөн.

7. Хэлтсийн 2020 оны сургалтын төлөвлөгөөний дагуу аймгийн Тагнуулын хэлтэстэй хамтран Төрийн болон байгууллагын нууцтай холбоотой сургалтыг онлайнаар авч сургалтын сэдвийг хэлтсийн хамт олны фэйсбүүк группт байршуулаж мэдээлсэн.

8. Улсын бүртгэлийн ерөнхий газраас ирүүлсэн чиглэл, хөтөлбөрийн дагуу сургалтын бэлтгэл ажлыг ханган тус хэлтсийн нийт албан хаагчид болон итгэмжлэгдсэн ажилтнаар томилогдсон Аймаг, нийслэл, сум дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн 40 хэсгийн хороонд ажиллах 44 итгэмжлэгдсэн ажилтнуудад холбогдох сургалтуудыг 2020 оны 10 дугаар сарын 07, 08-ны өдрүүдэд УБЕГ-ын Сургалтын багтай хамтран аймгийн Засаг даргын Тамгын газарт танхимаар амжилттай зохион байгуулан ажилласан.



9. УБЕГ газрын Улсын бүртгэлийн нэгдсэн архивын газрын дарга С.Оюунгэрэлээр ахлуулсан сургалтын баг "Улсын бүртгэлийн багц хуулийн хэрэгжилтийг хангах, улсын бүртгэлийн байгууллагын албан хаагчдын хууль эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэхтэй холбогдуулан чиглэл өгөх" сургалтыг 2020 оны 10 дугаар сарын 08 ны өдөр тус аймагт танхимын болон ажлын байранд дадлагжуулах хэлбэрээр зохион байгуулж хэлтсийн нийт албан хаагч хамрагдсан.



АРВАН ГУРАВ. 2020 ОНД ХИЙЖ ГҮЙЦЭТГЭСЭН ОНЦЛОХ АЖЛУУД

1.Тус хэлтсээс 2020 онд **“Сэтгэл, зүтгэл, гүйцэтгэлийг эрхэмлэе”** гэсэн уриаг дэвшүүлэн хэлтсийн **зорилго, уриаг** үйлчилгээний танхимд бичиж байршуулсан.



2.Хамт олны эв нэгдлийг бэхжүүлэх, харилцан ойлголцох бие биенээ дэмжин баг болж хамтран ажиллах, тэднийг хөгжүүлэх, шинэлэг мэдээ мэдээлэл солилцох зорилгоор хэлтсийн даргын баталсан төлөвлөгөөний дагуу албан хаагчид 2, 2-оороо баг болон дараах сэдвүүдээр мэдээлэл бэлтгэн хамт олны пэйж хуудаст байршуулан нийт албан хаагчиддаа онлайнаар мэдээлэл хийж танилцуулсан.

- Аз жаргал гэж юу вэ?, Аз жаргалын индексийн тухай
- Эерэг сэтгэлгээ, хандлагын боловсрол
- Технологийн хувьсгал, криптовалютын талаарх ойлголт
- Хэрхэн сайн аав, сайн ээж байх
- Хүүхдийг үл хайхрах
- Үнэгүй өгч болдог хамгийн үнэтэй зүйл
- Ажлын байрны дасгал хөдөлгөөн
- Сагсан бөмбөгийн үүсэл, хөгжил
- Эмэгтэйчүүдийн эрүүл мэнд
- Өглөөний гайхамшиг зэрэг болно.

3.Хэлтсийн нийт албан хаагчид эхний хагас жилд хийж гүйцэтгэсэн ажлын тайланг 2020 оны 06 дугаар сарын 12 ны өдөр албан хаагч 1 бүрчлэн хамт олныхоо дунд илтгэл тавьж танилцуулах ажлыг зохион байгуулсан.





Энэ ажлыг зохион байгуулснаар албан хаагчид бие биенийхээ хийж гүйцэтгэсэн ажилтай танилцаж , бусдаасаа санаа авч, суралцах, илтгэх ур чадвараа сайжруулах давуу талтай юм.

4.Хэлтсийн албан хаагчдыг гэр бүл, үр хүүхэддээ анхаарал, халамж тавих нөхцлийг хангах зорилгоор хүүхдийнх нь мэндэлсэн өдрөөр чөлөө олгож ажиллаж байна. Тайлангийн хугацаанд хүүхдийнх нь мэндэлсэн өдрөөр 21 албан хаагчдад чөлөө олгосон.

5.Хэлтсийн албан хаагчдын хурлаар хамт олны хуримтлал үүсгэх асуудлыг 2019 оны 10 дугаар сард хэлэлцэж хурлын тэмдэглэл хөтлөн баталгаажуулсан. Хамт олны 100 хувийн саналаар хуримтлал үүсгэх ажлыг өнгөрсөн оны 10 дугаар сараас эхлүүлсэн.Тус хуримтлалыг хариуцан ажиллах багийг хамт олны хурлаар 3 албан хаагчийн бүрэлдэхүүнтэйгээр томилсон ба тус баг хуримтлалыг албан хаагчдын ар гэрт гачигдал гарсан үед болон хамт олныг хамарсан үйл ажиллагаанд зарцуулах хуримтлалын журам боловсруулан батлуулж хэрэгжилтийг ханган ажилласан.

6.Бүх албан хаагчдийг хамруулсан бүртгэлийн үйл ажиллагаанаас гадна хэлтсийн бусад үйл ажиллагаанд оролцох ажил үүргийн хуваарийг 1 дүгээр улиралд боловсруулан баталж, хамт олны хурлаар танилцуулан үүрэгжүүлэн ажиллаж байна.

Ингэснээр улсын бүртгэгч нар болон бусад албан хаагчид байгууллагын үйл ажиллагаанд жигд оролцох байдал сайжирч, залуу албан хаагчид бусдаас суралцах боломж нөхцлийг бий болгосон.

7.Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын тушаал, чиглэл, зөвлөмж, шинээр батлагдсан хууль, журмыг тухай бүрд бүх албан хаагчид танилцуулан ажиллаж хэвшсэн.

8. Албан хаагчдын нийгмийн баталгааг хангах ажлын хүрээнд УБЕГ-ын гэрээг үндэслэн Дархан-Уул аймаг дахь Голомт банкны салбартай хамтран ажиллаж албан хаагчдын цалингийн зээлийн хүүг 1.3-1.5 % болгон бууруулж албан хаагчдад таатай нөхцлийг бий болгосон.

9.Улсын бүртгэлийн ерөнхий газрын Тамгын газарт 1 дүгээр улиралд албан хаагчдын зэрэг дэв, шатлалыг нэмүүлэх саналыг хүргүүлж Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын

2020 оны үйл ажиллагааны тайлан

2020 оны 03 дугаар сарын 20 ны өдрийн “ Төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэв олгох тухай” Б/156 дугаар тушаалаар хэлтсийн 18-н албан хаагчийн зэрэг дэв нэмэгдсэн.

10.Хэлтсийн байрны тохижилт, орчинг сайжруулах, үйлчлүүлэгчдийн ая тухтай байдлыг хангах ажлыг Иргэний улсын бүртгэлийн тасгаас санаачилан үйлчилгээний танхимыг тохижуулсан.



11.Байгууллагын үйлчилгээний стандартыг хэрэгжүүлэх, соёлыг дээшлүүлэх, үйлчлүүлэгчдийн ая тухтай үйлчлүүлэх нөхцөл байдлыг хангах зорилгоор ажлын байрны багана, ханад “Онч мэргэн үгс”-ийг оновчтой байрлалаар жаазлан байршуулсан.



12.Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн архивын цаасан эх нотлох баримт болох 5000 хувийн хэргийг цахим бүртгэлтэй тулгаж, тоолох ажлыг тус тасгаас санаачилан хэлтсийн даргын үүрэг гүйцэтгэгчийн 2020 оны 02 дугаар сарын 05 ны өдрийн А/02 дугаарын тушаал гаргуулан зохион байгуулан ажиллаж байна. 2020 оны 2 дугаар сараас эхлэн 5 улсын бүртгэгч, 1 архивчийн хамт сар бүр 500 хувийн хэргийг цахим сантай тулгаж, тоолох хуваарь гарган

2020 оны үйл ажиллагааны тайлан

ажилласнаар тайлангийн хугацаанд нийт 4600 хувийн хэргийг тулгаж,үлдсэн 400 хувийн хэргийг төлөвлөгөөний дагуу ондоо багтааж дуусгахаар ажиллаж байна.

Хувийн хэргийг цахим сантай тулгаж, тоолох явцад мэдээллийн санд өмчлөгчийн мэдээлэл дутуу, буруу болон огт оруулаагүй бүртгэлийн жагсаалтыг үйлдэн зөрчлийг арилгуулахаар хяналтын улсын байцаагч нарт улсын бүртгэгч нар хүсэлт гарган ажиллаж байна.

13.Иргэн, аж ахуйн нэгж байгууллагад бүртгэлийн үйлчилгээг түргэн шуурхай хүргэх зорилгоор Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тасгаас сар бүрийн 15-ны өдөр эд хөрөнгийн бүртгэлийн яаралтай үйлчилгээг өдөрт нь багтаан үзүүлэхээр тасгийн төлөвлөгөөнд тусгасны дагуу эхний хагас жилийн байдлаар 323-н бүртгэлийн яаралтай үйлчилгээг үзүүлсэн.

14.Дэлхий даяар тархаж буй шинэ коронавирусийн халдварын эрсдэлт нөхцөл байдлаас сэргийлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор Дархан-Уул аймгийн ИТХ-аас иргэддээ хандан гаргасан уриалгад хамт олноороо нэгдэн 2020 оны 03 дугаар сарын 06 ны өдөр аймгийн Онцгой комисст 600.000 /зургаан зуун мянга/ төгрөгийг хандивласан.



15.Тус аймагт зохион байгуулагдсан "Ковид-19" цар тахлын үеийн харилцан ажиллагаа, хариу арга хэмжээ" 3 өдрийн дадлага сургуулилтад хэлтсийн дарга хамрагдсан.



16.Томуу, томуу төст өвчин, шинэ төрлийн коронавирус /Ковид-19/ халдвараас урьдчилан сэргийлэх, учирч болох эрсдлийг бууруулах зорилгоор ажлын байрны их цэвэрлэгээг сар бүр тогтмол хийж хэвшсэн.



17.Тус хэлтсийн албан хаагчдын нийгмийн баталгааг хангах, амралт чөлөөт цагийг зүй зохистой өнгөрүүлэх арга хэмжээг хэрэгжүүлэх 2 багийг хэлтсийн даргын 2020 оны А/01 дүгээр тушаалаар томилсон. Үүнд:

1.Урлаг, соёл, олон нийт, нийгмийн баталгааг хангах, мөн эцэг эхийн зөвлөлийн үйл ажиллагааг хэрэгжүүлэх баг

Эцэг эхийн зөвлөлийн ажлын хүрээнд “Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдөр”-ийг тэмдэглэн өнгөрүүлэх өдөрт зориулан албан хаагчдынхаа хүүхдүүдийн дунд 3 насны ангилалаар ээж, аавдаа барих “Сэтгэлийн бэлэг” захидлын болон гар зургийн уралдааныг онлайнаар зохион байгуулж оролцсон хүүхдүүдээ 1-3 дугаар байр болон тусгай байрыг шалгаруулан урамшуулж бэлэг, дурсамж гардуулах ажлыг зохион байгуулсан.



2.Спорт, амралт чөлөөт цагийг зүй зохистой өнгөрүүлэх баг, тус баг нь 2020 оны төлөвлөгөө гарган хэлтсийн даргаар батлуулан ажиллаж байна. Тус багаас Монгол улсад Бүртгэлийн байгууллага үүсч байгуулагдсаны 80 жилийн ой, Бүртгэлийн ажилтны өдрийг тохиолдуулан төрийн байгууллагуудын дунд гар бөмбөгийн тэмцээнийг 2020 оны 10 дугаар сарын 31-ний өдөр амжилттай зохион байгуулсан.



18.Төрийн бус байгууллагатай хамтарч ажиллах ажлын хүрээнд тус аймаг дах “Дархан Дулааны сүлжээ” ТӨХК –нд тус хэлтсийн байрны гадна тохижилтын ажилд хамтарч ажиллан дэмжлэг үзүүлэх хүсэлтийг албан бичгээр хүргүүлэн ажилласны дагуу тус байгууллагаас 362000 /гурван зуун жаран хоёр мянга/ төгрөгийн үнэ бүхий гадна хашааны төмрийг нийлүүлж хөрөнгийн дэмжлэгийг авч байгууллагын гадна зүлэгний хашлага хийсэн.

19.2020 оны 11 сарын 16-ны өдөр нийт хэлтсийн албан хаагчдыг PCR шинжилгээнд хамруулсан.



20.Аймгийн онцгой комиссын шийдвэрээр аймгийн хэмжээнд 96 цаг 0 зогсолт хийгдэж, бүх нийтийн бэлэн байдалд шилжсэн үед 6, 7, 8, малчин багийн иргэдийн хүнсний захиалгыг цахим хэлбэрээр болон утсаар авч 28-н хүнсний дэлгүүрүүдтэй хамтран ажиллаж хүнсээр хангах, түгээх, дэлгүүрүүдийн ажилчдыг шинжилгээнд хамруулах, ажиллах зөвшөөрөл олгох, үнийн өсөлт, барааны хангалт, халдвар, хамгаалалтын дэглэм сахиулах ажлыг хариуцан зохион байгуулан ажилласан.



21.Дархан-Уул аймгийн Онцгой комиссын шийдвэрээр 2020.11.24-2020.11.26- ны өдрүүдэд "Нэг өрх – нэг иргэн" PCR шинжилгээ авах ажлыг зохион байгуулахад Дархан сумын 3 дугаар багийн 1386 өрхийг шинжилгээнд хамруулах, мэдээ тайланг гаргаж хугацаанд нь хүргүүлэх ажлыг хариуцан ажилласан.



22.Өөр аймаг орон нутагт хөл хорионд орсон иргэдийг татан авах ажлын хэсэгт орж нийт 7000 гаруй иргэдийг татан авах ажлыг хийж гүйцэтгэж байна. Өндөржүүлсэн бэлэн байдлын хугацаанд ирэх, явах иргэдийн судалгааг ангилан гаргасан.



23.Аймгийн Онцгой комиссоос өгсөн чиглэлийн дагуу тус аймгаас буцах хүсэлтээ цахимаар өгсөн нийт 1852 иргэнээс 334 иргэнтэй утсаар холбогдож холбогдох мэдээллийг асуумжаар авах ажлыг хийж гүйцэтгэсэн.



24.Дэлхий даяар тархаж буй шинэ коронавирусийн халдварын эрсдэлт нөхцөл байдлаас сэргийлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор Сэлэнгэ аймаг дахь хэлтсийн улсын ахлах бүртгэгч болон Сэлэнгэ аймаг хэлтсийн хамт олонд 270.000 / хоёр зуун далан мянга/ төгрөгийг хамт олноороо нэгдэн хандивласан.



25. Улсын онцгой комиссын болон аймгийн онцгой комиссын шийдвэр, Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2020 оны А/1455 дугаар тушаалын хэрэгжилтийг ханган ажиллаж хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгчийн “Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэн үеэр ажиллах хариуцлагатай жижүүрийн хуваарь батлах тухай” 2020 оны 11 дүгээр сарын 12 ны өдрийн А/14, “Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэн үеэр ажиллах хариуцлагатай жижүүрийн хуваарь батлах тухай” 2020 оны 11 дүгээр сарын 16 ны өдрийн А/15, “Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжсэн үеэр ажиллах хариуцлагатай жижүүрийн хуваарь батлах тухай” 2020 оны 12 дугаар сарын 01ний өдрийн А/16 дугаарын тушаалуудын хэрэгжилтийг ханган ажиллаж, ажилласан тухай хариуцлагатай жижүүрийн мэдээ мэдээллийг өдөр бүр УБЕГ-т хугацаанд нь хүргүүлэн ажилласан.

26 Халдварт өвчин гарсантай холбогдуулан хэлтсийн дарга нь Хүнс тараах, Нэг иргэн-Нэг өрх PCR шинжилгээ, Иргэдийг татан авах ажлын хэсэгт ажиллаж байгаа бөгөөд уг хугацаанд ажилдын халдвар хамгааллын дэглэм сахиулах хувцас хэрэгсэл, хоол, унааны зардлыг тухайн байгууллага шийдвэрлэн ажиллахаар Аймгийн онцгой комиссоос өгсөн үүрэг даалгаврын хүрээнд Халдвар хамгаалалтыг дэглэмийг чанд мөрдөж ажиллах үүднээс албан хаагчдын хэрэгцээнд зориулж 1.850.000 /нэг сая гурван зуун далан мянга/ төгрөгийн өртөг бүхий 2000 ширхэг маск, хамгаалалтын хувцас 50ш, нүүрний хаалт 20 ширхэгийг, шатхууны зардал/480000/ хэлтсийн хамт олон өөрсдийн зардлаар шийдвэрлэн ажиллаж байна.

АРВАН ДӨРӨВ. ЦААШИД ШИЙДВЭРЛҮҮЛЭХЭЭР ТУЛГАМДАЖ БУЙ АСУУДАЛ

Тус хэлтэс нь бүртгэлийн үйл ажиллагаагаа хэвийн явуулж иргэдэд бүртгэлийн үйлчилгээг түргэн шуурхай хүргэх, албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангаж ажиллахад дараах тулгамдсан асуудал үүсээд байна. Үүнд:

1. Хэлтэс өөрийн байргүй, түрээсийн байранд байрлаж байгаа бөгөөд түрээсэлж буй аймгийн ЗДТГ-ын 2 дугаар байр харуул хамгаалалтгүй, албан хаагчид өөрсдөө өдөр өдрөөр ээлжлэн жижүүрийн үүргийг гүйцэтгэн ажилладаг.

3. Тухайн байрны өрөө тасалгаа хүрэлцээ, багтаамж муутайгаас 1 өрөөнд олноороо сууж ажилладаг ба архивын өрөөнүүд стандартын бус, зай талбай хүрэлцээгүй улмаас нэмж тавиур, баримт байрлуулах боломжгүй болсон.

4. Сумдын улсын бүртгэгч нарын албан хэрэгцээнд ашиглаж буй зөөврийн компьютер бусад тоног төхөөрөмж удаан эдэлснээс бүртгэл хөтлөхөд хүндрэлтэй байдал үүсэж байна.

5. ЭХЭУБ-ийн тасгийн 5 улсын бүртгэгчийн дунд 2 скайнер ашиглаж байгаа мөн сүлжээний хурд бага тул ажлын бүтээмж муу, илүү цагаар сууж ажиллаж байна.

6. Хуулийн этгээдийн улсын бүртгэгч скайнаргүйгээс ажлын бус цагаар ЭХЭУБТ-ын скайнерийг ашиглаж байна.

7. Архивын стандартын нягтруулсан шүүгээ авах санал хүргүүлснийг харгалзан үзэж зардлыг төсөвт тусгаж баталж өгөх.

8. Албан хаагчдын албан хэрэгцээнд ашиглаж буй суурин компьютер, принтерүүд бүгд ашиглалтын хугацаа дууссан, гэмтэлтэй, үзүүлэлт муу, зарим нь засварлах боломжгүй болсон тул тоног төхөөрөмжийг шинэчлэх.

9.Цалингийн сан хүрэлцэхгүй.

10.Бичиг хэргийн зардал хүрэлцэхгүйгээс албан хаагчид өөрсдийн зардлаар бичгийн цаас бусад хэрэгслийг авч албан хэрэгцээндээ хэрэглэж байгаа тул зардлыг нэмэгдүүлэх

11.Шуудан холбооны зардал хүрэлцэхгүйгээс өр үүсэж байгаа тул зардлыг нэмэгдүүлэх

12.Нярав, бичиг хэргийн ажилтан, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэгч нарын ажлын ачаалал их байх тул орон тоог нэмж өгөх

13. Монгол Улсын Гамшгаас хамгаалах тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.2-т заасан хөрөнгийн эх үүсвэрийг төсөвт тусгаж өгөх /Дархан-Уул аймгийн Онцгой байдлын газрын даргын баталсан 2020 оны 09 дүгээр сарын 21-ны өдөр “Гамшгаас хамгаалах бэлэн байдлын үзлэг явуулах” удирдамжийн хүрээнд Иргэний бүртгэл, мэдээлэл статистикийн мэргэжлийн ангийн бэлэн байдлыг шалгаж Гамшгаас хамгаалах улсын хяналтын байцаагчийн 2020 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн мэдэгдэлийг ирүүлсэн бөгөөд уг мэдэгдэлд дурдагдсан үйл ажиллагааны онцлогт нийцүүлэн анги байгуулах, шаардагдах техник, материал, нэг бүрийн хамгаалах хэрэгсэлээр хангах, мэргэжлийн анги бүрэлдэхүүн болон ажилтныг гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд сургаж бэлтгэн бэлэн байдлыг хангах, гамшгаас хамгаалах орон нутгийн нөөц бүрдүүлэх ажил хийгдээгүй/

ХЯНАСАН:

ХЭЛТСИЙН ДАРГЫН ҮҮРГИЙГ

ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

М.ХУВЬЗАЯА

БИЕЛЭЛТ ГАРГАСАН:

ИУБТ-ИЙН ДАРГА БӨГӨӨД

УЛСЫН АХЛАХ БҮРТГЭГЧ

Ш.БАЯРМАА